



СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.05.28 №21 (10698)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

МЭНДЧИЛГЭЭ



Хүн төрөлхтний амар амгалан, энх тайвны төлөө үйл хэрэгт бодит хувь нэмрээ оруулж, Монгол Улс, Монгол цэргийн нэр хүндийг дэлхийн тавцанд өндөрт өргөсөн эрхэм генерал, офицер, ахлагч, гэрээт албаны түрүүч, байлдагч нар болон хилийн чанадад энхийг сахиулах үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгаа нийт цэргийн алба хаагчид Та бүхэндээ “Энхийг сахиулагчдын өдөр”-ийн мэндчилгээг өргөн дэвшүүлье.

Араб-Израйлын хооронд байгуулсан гал зогсоох хэлэлцээрийг хянах зорилгоор цэргийн ажиглагчдыг 1948 оны 5 дугаар сарын 29-ний өдөр анх илгээсэн түүхтэй бөгөөд түүнээс хойш энэхүү өдрийг “Олон улсын энхийг сахиулагчдын өдөр” болгон тэмдэглэсээр ирсэн.

Энэхүү өдрийн гол зорилго нь цэнхэр дуулгалан-энхийг сахиулагчдын мэргэжлийн ур чадвар, хичээл зүтгэлийг алдаршуулах, энхийн үйл хэргийн төлөө амиа өгсөн алба хаагчдын гэгээн дурсгалыг хүндэтгэхэд чиглэгдсэн ирсэн.

Өнөөдрийн байдлаар НҮБ-ын 13 энхийг дэмжих ажиллагаанд дэлхийн 120 орны 97 мянга гаруй энхийг сахиулагчид үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд Монгол Улс цэрэг хандивлагч орнуудын жагсаалтад 24 дүгээрт бичигдэж байна. Тодруулбал, манай улсын Зэвсэгт хүчний цэргийн баг, цэргийн алба хаагчид НҮБ-д дэлхий дахины энх тайван, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт 2002 оноос хойш идэвхтэй оролцож, энэ хугацаанд давхардсан тоогоор 18000 орчим “цэнхэр дуулгалан”-цэргийн алба хаагчид үүргээ нэр төртэй гүйцэтгээд байна.

Цаашид Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавч оролцоог нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээний хүрээнд түргэн байрлах хүчний рот, инженерийн ротыг НҮБ-ын цэргийн хүчний шаардлагад заагдсан бүтэц, зохион байгуулалтын дагуу НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чадварын бэлэн байдлын системд 1 дүгээр түвшинд бүртгүүлээд байна.

Монгол Улс Энхийг сахиулах ажиллагаанд оролцсоноор хүн төрөлхтөн, Олон улсын хамтын нийгэмлэг, НҮБ-ын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний хөгжлийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх боломж, чадавхыг нэмэгдүүлэх, бие бүрэлдэхүүний цэргийн хэргийн ур чадвар, туршлагыг дээшлүүлэх чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Зэвсэгт хүчин хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийнхээ зэрэгцээ даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, бэхжүүлэх ариун үйлсэд эх орон, ард түмнээ төлөөлөн оролцож, Монгол Улсынхаа нэр хүндийг дэлхийн тавцанд өргөн мандуулахын зэрэгцээ Зэвсэгт хүчнийхээ түүхийн хуудсыг улам бүр баяжуулсаар байгаад миний бие бахархалтай байдаг.

Та бүхний даян дэлхийд энх амгалан байдлыг хангах үйл хэрэгт оруулах их үйлсэд улам их амжилт гаргахыг хүсэн ерөөе.

Монгол цэргийн сүлд хийморь, сүр жавхаа үеийн үед мандан бадрах болтугай!

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Н.ЭНХБОЛД



НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн, үүргээ нэр төртэй биелүүлж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний болон Төрийн цэргийн байгууллагуудын алба хаагчид-Цэнхэр дуулгалан Та бүхэнд ЗХЖШ-ын даргын зөвлөлийн өмнөөс болон хувиасаа “Энхийг сахиулагчдын өдөр”-ийн баярын мэндийг хүргэе.

Даян дэлхийн улс орнуудтай хаяа дэрлэн энх тайвнаар зэрэгцэн оршиж буй Монгол Улсын энхийг эрхэмлэсэн олон тулгуурт, нээлттэй гадаад бодлогыг хэрэгжүүлэхэд энхийг сахиулагчдын оруулсан хувь нэмэр, гүйцэтгэж буй үүрэг үлэмж их билээ.

Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн 2002 онд энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлснээс хойших хугацаанд 18000 гаруй энхийг сахиулагч үүргээ амжилттай гүйцэтгэж, өнөөдрийн байдлаар дэлхийн халуун цэгүүдэд 1100 гаруй цэргийн алба хаагч үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгааг онцлон тэмдэглэхэд таатай байна.

Энхийг сахиулагч монгол дайчид цагийн байдлын хүнд нөхцөлд мэргэжлийн ур чадвар, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл, сахилга зохион байгуулалтаараа ижил түвшний цэргийн багуудаас ямагт дээгүүр байж, НҮБ, цэргийн хүчний командлал, орон нутгийн иргэдийн сайшаал, магтаал, талархлыг удаа дараа хүртсээр байгаа нь бид бүхний амжилт юм.

Эх орон, Төр, засаг, Зэвсэгт хүчнийхээ өмнө хүлээсэн хүндтэй бөгөөд хариуцлагатай үүргээ нэр төртэй биелүүлж, энхийг дэмжих ажиллагааны явцад олж авсан мэдлэг, дадлага, туршлага тань Та бүхний ирээдүйн ажил үйлс, цаашлаад Монгол Улсын Зэвсэгт хүчний хөгжил, дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэл дүүрэн байна.

Энэхүү тэмдэглэлт өдрийг тохиолдуулан эх орныхоо өмнө өргөсөн тангарагтай үнэнч мөрдэс нэгт нөхдийн маань үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлэн тэдний найдвартай ар тал болж, сэтгэл зүрхээрээ үргэлж хамт байдаг ар гэр, ах дүү, төрөл төрөгсөд, найз нөхөд, хамт олон Та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлж, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Монгол цэргийн нэр хүндийг өндөрт өргөн, дэлхийн чихнээ дуурсгаж байгаа энхийг сахиулагч Та бүхний даян дэлхийн энхийн төлөө ариун үйлсэд оруулж буй хувь нэмэр, бахархам үйлс өдрөөс өдөрт арвижин батжиж, Монгол цэргийн сүр хүч, цог золбоо үеийн үед мандан бадрах болтугай!

МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ

“ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫН ӨДӨР”-ИЙН БАЯРЫН МЭНД ХҮРГЭЕ!



Абьёмном суурин руу холын эргүүлийн үүрэг гүйцэтгэх үеэр. БНӨСУ. 2020.04.28

НЭГ САЯ ЮАНИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙГ ХҮЛЭЭЛГЭН ӨГЛӨӨ

БНХАУ-ын Батлан хамгаалах яамнаас Монгол Улсын Батлан хамгаалах яаманд коронавирусийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор нэг сая юанийн өртөг бүхий эмнэлгийн хамгаалах хэрэгсэл, эмч, сувилагч, ажилтан, албан хаагчдын хамгаалалтын хувцас хэрэглэлийг буцалтгүй тусламжаар өгснийг тус улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цай Вэньруй Батлан хамгаалахын сайд Н.Энхболдод хүлээлгэн өглөө.

Эмнэлгийн хамгаалалтын хувцас, хэрэглэлийг хүлээлгэх баримтад Батлан хамгаалах яамны БХЗГ-ын дарга, хурандаа Х.Батсайхан, БНХАУ-аас Монгол

Улсад суугаа ЭСЯ-ны Цэргийн атташе, ахлах хурандаа Бао Юйхай нар гарын үсэг зурсан юм.

Энэ үеэр Батлан хамгаалахын сайд Н.Энхболд “Цар тахалтай тэмцэж байгаа энэ үед БНХАУ-ын Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчнээс Монгол Улсад бодитой тусалцаа үзүүлж нэг сая юанийн үнэ бүхий эмнэлгийн хамгаалах хэрэгсэл, тусгай зориулалтын багаж хэрэгсэл хүлээлгэн өгч байгаад баяртай байна. Хоёр орны хамтын ажиллагаа төдийгүй, энх тайвныг тогтоох, цэргийн итгэлцэл, стратегийн түншлэлийн харилцаанд томоохон хувь нэмэр оруулсан үйл явдал болж байна. Манай улсын хувьд хил хязгааргүй тархаж байгаа цар тахалтай тэмцэхэд өөрсдөөсөө шалтгаалах



арга хэмжээг авч хэрэгжүүлж, дотооддоо халдвар тараалгүй, хяналтдаа байлгаж чадаж байна. Олон улсын туршлага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжөөс харахад тэргүүн эгнээнд, эрсдэл бүхий нөхцөлд ажиллаж байгаа эмнэлгийн ажилтнуудыг халдвараас хамгаалах асуудал чухал байна. Ингэж чадсанаар эрүүл мэндийн салбарынхаа хамгаална, нийгэмд халдвар тархахгүй байх нөхцөл бүрдэнэ. Монгол Улсын Засгийн газар, иргэд цар тахалтай тууштай тэмцэж байгаа бөгөөд үүнд Батлан хамгаалах салбарын үүрэг, оролцоо чухал байр суурь эзэлж байна.

(Үргэлжлэл нь II нүүрт)

Н.Эрдэнэбаяр: ХӨДӨӨ, ОРОН НУТГИЙН ЗАРИМ АНГИ, САЛБАРТ ҮРГЭЛЖИЛНЭ

Улаанбаатар цэргийн хүрээний Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад алба хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчдад шүд, амны хөндийн тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг 2 дугаар сарын 10-ны өдрөөс эхлүүлсэн. Энэ талаар ЗХЖШ-ын Ар талын газрын Эрүүл мэндийн хангалтын хэлтсийн мэргэжилтэн, ахлах дэслэгч Н.ЭРДЭНЭБАЯРААС зарим зүйлийг тодрууллаа.

Ангиудын байнгын бие бүрэлдэхүүнээс тодорхой санал, хүсэлт ирүүлсэн гэсэн. Энэ талаар ...

—Ангиудын байнгын бие бүрэлдэхүүний дунд шүд, амны хөндийн өвчлөл элбэг байна. Тэр бүр үзүүлээд, эмчлүүлээд байх боломжгүй тул хөдөлгөөнт бүлэг томилж, тусламж, үйлчилгээ үзүүлэхийг хүссэн тухай санал, хүсэлт нэлээд ирж байна. Үүнтэй холбоотойгоор хөнгөлөлттэй үнээр үзлэг, тусламж үйлчилгээ үзүүлэх хөдөлгөөнт бүлэг томилон ажиллуулахад шаардлагатай тооцоо, судалгаа, эрх зүйн баримт, бичгийг боловсруулан ажиллаж байна.

Энэхүү ажил цаашид хэрхэн өрнөх вэ?

—Өмнө нь шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хөдөлгөөнт бүлэг томилон ажиллуулж байгаагүй ба энэхүү ажил нь цаашид хөдөө орон нутгийн зарим анги, салбарт үргэлжилнэ. Коронавирусийн цар тахлын үед гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдаа хүрч ажиллаж байгаа нь нэн ач холбогдолтой юм.



хувьд нь эмчилгээ хийгдэж байгаа тул дээрх тоо тэг хүртэл буурах боломжтой юм. Зарим эмчилгээ цаг хугацаа их шаарддаг. Жишээлбэл, сувгийн эмчилгээ л гэхэд хамгийн багадаа 2-3 долоо хоног хийгддэг.

Юуны өмнө дээрх ажлын явцын талаар тодруулахгүй юу?

—ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон шүдний эмч нарын бүлэг одоогоор Зэвсэгт хүчний 013, 014, 016, 119, 120, 311, 326 дугаар ангид ажиллан гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдад шүд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эмчилгээг хийгээд байна. Үзлэгт хамрагдсан хугацаат цэргийн алба хаагчдын 70 гаруй хувь нь өвчлөлттэй байсныг нь эрүүлжүүлж, холбогдох сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Зонхилон тохиолдож байгаа өвчлөлийн тухайд ...

—Дийлэнх нь шүд цоорох болон амны хөндийн тулгуур эдийн өвчлөл гэж хэлж болно. Энэ өвчлөлийн тархалт анх 85 хувьтай байсан бол эмчилгээ хийгдсэнээр 25,5 хувь хүртэл буурсан. Одоогоор үлдсэн 25,5

ЦДБЭЧ-ын эргэн тойронд ...

УРАН БҮТЭЭЛЧДИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫГ НЭГТГЭН ДҮГНЭЛЭЭ

“Чуулгын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх, “2019-2020 оны цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг ханган ажиллах бодлогын хүрээнд “Уран бүтээлийн судалгааны ажил”-ыг бие даалтаар өгч, нэгтгэн дүгнэлээ. Монголын урлагийн өв сан дахь дахин давтагдашгүй шилдэг бүтээлүүд төдийгүй ЦДБЭЧ-ын үеийн уран бүтээлчдийн бүтээн туурвиж, өвлүүлэн үлдээсэн 116 бүтээл судлагдсан юм. Уран бүтээлчид өөрсдийн мэргэжлийн онцлогоос хамааран дуу, хөгжим, бүжиг, тайз засал гэсэн үндсэн чиглэлээр бүтээлүүдээ сонгон авч бүтсэн түүх, уран бүтээлчдийн намтар, тоглогдсон байдал, тус бүтээлийнхээ онцлог, хэв маяг,

ШИНЭ УРАН БҮТЭЭЛ-ШИЛДЭГ УРАН БҮТЭЭЛЧДИЙГ ШАЛГАРУУЛЛАА

Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын урын санг цэрэг-эх орны сэдэвт бүтээлээр баяжуулах, гоцлол уран бүтээлчдийг дэмжих, хамт олны бүтээлч санаачилгыг хөгжүүлэх, уран бүтээлийн ололт амжилтыг дүгнэж үнэлэх, цаашид чуулгын тоглолт, урын санд орох боломж бүхий чанартай уран бүтээлчдийг тодруулах зорилготой “Шинэ уран бүтээл-Шилдэг уран бүтээлч шалгаруулах уралдаан”-ыг амжилттай зохион байгууллаа.

Уралдааны “Шинэ уран бүтээл”-ийн төрөлд 36 бүтээл өрсөлдсөнөөс Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, МУУГЗ Б.Шаравын хөгжим, СТА О.Ууганбаярын дэглэлт “Эх орон” олуул бүжгийн бүтээл тэргүүн байр, Хөдөлмөрийн баатар, Төрийн хошой шагналт, Ардын

Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, МУУГЗ Б.Шаравын хөгжим, Д.Пүрэвдоржийн шүлэг “Монгол туургатны гал голомт” дуугаар МУГЖ Б.Батбаатар дэд байр, Chuck Mangione-ийн “Love the feeling” бүтээлээр хөгжимчин, МУСТА Ц.Отгонбаатар гутгаар байрын шагналыг тус тус хүртлээ.

Тус уралдааныг Улсын онцгой комиссын заавар зөвлөмжийн дагуу сахилга, зохион байгуулалтын өндөр түвшинд мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээлчдийн төлөөллүүд шүүн явуулсан юм.

“СҮЛДЭН ЗАЯАТАЙ ЭХ ОРОН”

Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу “Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор ЗХЖШ, Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын санаачилга, Батлан хамгаалах яамны дэмжлэгтэйгээр хийгдэж буй “Сүлдэн заяатай эх орон” телевизийн нэвтрүүлгийн зураг авалт явагдаж байна.

“Дуулга” студийн уран бүтээлчдийн хийж буй тус нэвтрүүлгээр Монгол Улсын Төрийн Соёрхолт, Ардын Уран Зохиолч, Соёлын Гавьяат Зүтгэлтэн Д.Цоодол, Төрийн шагналт, СГЗ Д.Төрбат, Ардын Жүжигчин Г.Равдан, СГЗ Г.Чулуунбат зэрэг хүндтэй яруу найрагч, нэвтрүүлэгчид оролцон цэрэг-эх орны сэдэвт шилдэг бүтээлүүдийн дээжсээ толилуулж байгаа аж. Зураг авалт Зэвсэгт хүчний анги, байгууллагууд, манай орны байгалийн үзэсгэлэнт газруудад хийгдэж байна.

Дашрамд, ЦДБЭЧ Олон улсын энхийг сахиулагчдын өдөрт зориулсан онлайн тоглолтыг “TV-5” телевизтэй хамтран зохион байгуулахаар ажиллаж байна.



дэглэлт, Монголын урлагийн түүхэнд үзүүлсэн нөлөөлөл зэргийг судалсан байна.

Энэхүү судалгааны ажил нь 88 жилийн баялаг түүхтэй ЦДБЭЧ-ын урын сангийн шилдэг бүтээлүүдийг судлан мэдэх, тэдгээрийг эрдэм шинжилгээ судалгааны эргэлтэд оруулах, уран бүтээлчдийн бүтээлч хандлагыг нэмэгдүүлэх олон талын ач холбогдолтойгоороо онцлог байлаа.

жүжигчин Н.Жанцаноровын хөгжим, СТА Ж.Отгончулууны найруулга “Хүннү цэрэг” дан хөгжмийн бүтээл дэд байр, СТА О.Ууганбаярын дэглэлт “Хун галуу” олуул бүжгийн бүтээл гутгаар байрт шалгарлаа.

Мөн “Шилдэг уран бүтээлч”-ийн төрөлд 23 хүн өрсөлдсөнөөс УГЗ Б.Бямбабаярын хөгжим, Э.Цэрэннямын шүлэг “Үнэний тамгатай Монгол” дуугаар дуучин Г.Мөнхбат тэргүүн байр,

Редакцын шууданд

“Алдар” спорт хороо



Батлан хамгаалах яамны харьяа, Зэвсэгт хүчний “Алдар” спорт хорооны удирдлага, багш, дасгалжуулагч, тамирчид “Бидний тарьсан хог биш, гэхдээ бидний орчин” уриан дор “Монгол шилтгэн”-ээс Улиастайн гүүр хүртэлх Туул гол орчмын эрэг дагуух 11,8 километр газрын 19 тонн хогийг цэвэрлэв. Баянзүрх дүүргийн Тохижилт, үйлчилгээний компани техник, хэрэгслээр дэмжлэг үзүүлж ажиллалаа.

013 дугаар анги

Харуулын салаа, туслах аж ахуйн хамт олноос ангийн үйл ажиллагааг дэмжин таван ханатай иж бүрэн гэрийг ангийн захирагч, хурандаа С.Пүрэвдорж болон захирагчийн зөвлөлийн гишүүдэд хүлээлгэн өглөө.

Мөн шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор авто тээвэр, засварын салааны захирагчийн орлогч, ахлах ахлагч Н.Ууганцэцэг 100 гаруй амны хаалт, бээлийг ангийн штабын бүрэлдэхүүн, ар талын офицеруудад хүлээлгэн өгч дэмжлэг үзүүлээ.

Ахмад С.БАТБААТАР

336 дугаар анги

“Олон улсын сувилагч нарын өдөр”-ийг тохиолдуулан ангийн Эмнэлгийн алба-эрүүл мэндийн төвийн хамт олон бие бүрэлдэхүүнийг витаминжуулж, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдаа амны хаалт тараалаа. Мөн офицер, ахлагч нарын гэр бүлийн төлөөллүүдээс гурван өндөр настанд асаргаа, сувилаганд шаардагдсан эмийн сан, бусад эм тариаг хүлээлгэн өглөө.

Ахмад О.ОТГОНЦЭЦЭГ

НЭГ САЯ ЮАНИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙГ ХҮЛЭЭЛГЭН ӨГЛӨӨ

(Түрүүч нь I нүүрт)

Монгол Улсын Батлан хамгаалах яамны харьяа Цэргийн төв эмнэлэг нь тусгаарлалт, эмчилгээний гол эмнэлгүүдийн нэг болон ажиллаж байгаа энэ чухал, хариуцлагатай үед хамгаалах хувцас, гутал, нүдний шил, шүүлтүүртэй болон нэг удаагийн амны хаалт, зайнаас халуун хэмжигч зэрэг эмнэлгийн хэрэгслийг тусламжаар өгснөөр манай цэргийн эмч, сувилагч, эмнэлгийн ажилтан, албан хаагчдын ажилд маш том дэмжлэг үзүүлээ. Цэргийн төв эмнэлэгт гаднаас ирсэн иргэд тусгаарлагдаж байгаагаас гадна эмнэлгийн хяналтад байж эмчилгээ хийлгэх шаардлагатай хүмүүст эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг давхар гүйцэтгэж байна. Манай эмнэлгийн эмч, ажилчид бүрэн бүрэлдэхүүнээрээ ээлжээр ажиллаж байгаа учир тэднийхээ эрүүл мэндийг хамгаалах, гадагш халдвар алдахгүй байх талаар ихээхэн анхаарал хандуулж байгаа. Хэдийгээр нөхцөл байдал хүнд, бэрхшээл, сорилт их байгаа боловч мөнхийн найрсаг хөрш Хятад улс болон Олон улсын хамтын нийгэмлэгтэй нягт хамтран ажиллаж, цар тахлыг гарз хохирол багатайгаар даван туулна гэдэгт итгэлтэй байна” гэв.

Мөн БНХАУ-аас Монгол

Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цай Вэньруй “Хятадын ард түмэн тахал өвчинтэй тэмцсэн хүнд хэцүү үед Монгол Улсын төр засаг, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчин, иргэдэд сэтгэлийн дэм үзүүлж тусламжийн гараа сунгасан билээ. Энэ нь хоёр орны Зэвсэгт хүчний хамтын ажиллагаа, найрсаг харилцааг харуулсан юм. Үүнийг Хятадын ард түмэн, тэр дундаа Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн бид мартаггүй. Монголчууд цар тахалтай тэмцэхэд үр дүнтэй ажиллаж байгааг энд дурдах хэрэгтэй. Монгол Улс дотооддоо халдвар авсан тохиолдол гараагүй нь бахархалтай. Гаднын орнуудаас тэвэрлэгдэн ирж байгаа иргэдээ тусгаарлан хяналтдаа авч чадаж байна. Монгол Улсын Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний цар тахалтай тэмцэх ажлыг нь дэмжиж Хятадын Батлан хамгаалах яамнаас хамгаалах хувцас хэрэгсэл, эмнэлгийн хэрэгслийг тусламж болгон ийнхүү өгч байна. Сүүлийн жилүүдэд хоёр орны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа, найрсаг харилцаа тасралтгүй өргөжин хөгжиж байна. Энэ найрсаг харилцаа, хамтын ажиллагааг улам хөгжүүлэн, бэхжүүлэхэд БНХАУ-ын Элчин сайдын яам тууштай ажиллана гэдгээ илэрхийлэв. Та бүхэнд эрүүл энх, ажлын амжилт хүсье” гэсэн юм.

МОНГОЛ УЛСАД НИСЭХ ХҮЧИН ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ 95 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ



Монгол Улсад Нисэх хүчин үүсэж, хөгжсөний түүхт 95 жилийн ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын бие бүрэлдэхүүн оролцлоо. Энэ үеэр Ми-24В онгоцны зэвсэглэл, холбоо, навигаци, аэродром, газрын тусгай үйлчилгээний техник, хэрэгслүүдийг дэлгэн танилцуулсан. Түүнчлэн, ажил, үүргээ манлайлан гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагчдыг одон, медалиар шагнаж урамшуулсны зэрэгцээ ахлах дэслэгч М.Бат-Өлзий, дэслэгч Х.Хангал, дэслэгч Г.Амарсайхан нар сургууль, дадлагын нислэг үйлдэж, аэродромын районд бие даасан нислэг үйлдэх эрх авсан нь онцлох үйл явдал боллоо.

Дашрамд, 1925 оны 5 дугаар сарын 25-ны өдөр “Ю-13” загварын онгоцыг Зөвлөлтийн нисгэгч А.А.Лапин ахлан Улаан-Үүдээс нисгэж тухайн үеийн Улаанбаатар хотын Консулын дэнж (Офицеруудын тойрог) дээр буулт хийсэн цаг үеэс манай оронд Нисэх хүчин үүссэн гэж үздэг.

ДОКТОРЫН ЗЭРЭГ ХАМГААЛНА

Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургуулийн докторант Ж.Цогтсугар “Нийгмийн аюулгүй байдалд архидалтын үзүүлж буй нөлөөлөл, түүнийг бууруулах арга зам” сэдвээр “Аюулгүй байдал” чиглэлээр доктор (Ph.D)-ын зэрэг хамгаална. Хамгаалуулах зөвлөлийн хуралдаан 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 14.00 цагт тус сургуулийн “Сүбээдэй” танхим (Хичээлийн нэгдүгээр байрны 212 тоот)-д болно

БАТЛАН ХАМГААЛАХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ДОКТОРЫН АЖИЛ ХАМГААЛУУЛАХ ЗӨВЛӨЛ

ХИЙХ ХҮНД АРГА ОЛДДОГ ХИЙХГҮЙ ХҮНД ШАЛТАГ ОЛДДОГ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан Бид Чингисийн үр сад, “Зөв тэмүүлэл-Эх оронч манлайлал” сургалт

Аймаг, сум, багт батлан хамгаалах чиглэлээр гарсан хууль тогтоомжийн биелэлтийг хангах, тайван болон онцгой нөхцөлийн үед тухайн чиглэлийн ажлуудыг зохион байгуулах, хэрэгжүүлэх, энэ чиглэлээр нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд мэргэшил, арга зүйн удирдлага, туслалцаа үзүүлэх, хяналт тавих ажлуудыг Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабууд хариуцан ажилладаг хуулийн заалттай. Энэ л үүргүүдийг нэр төртэй, амжилт бүтээлтэй гүйцэтгэж байгаа Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын үйл ажиллагааг сурвалжиллаа. Хийсэн ажилтай, үзүүлэх бүтээлтэй хамт олон гэхэд их л даруухан угтсан бөгөөд Цэргийн штабын дарга, хурандаа Г.Нэмэхбаяр “Оны өмнөхөн танай сонинд гарсан гэсээр биднийг угтсан. Бид ч сонинхоо нийтлэлийн бодлогоо “өмнөө” барин сурвалжлах ажлаа хийсэн юм.

Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб нь өнгөрсөн онд “Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний болон төрийн захиргааны ажилтнуудын цэргийн бэлтгэл, сургалтыг чанартай, үр дүнтэй явуулж, сургалтын материаллаг баазыг сайжруулахын зэрэгцээ орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх, дайчилгааны даалгаврыг хангахад чиглэн ажиллажээ. Онцолбол, 2019 онд “Оюутан цэрэг” цэргийн мэргэжил олгох сургалт, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийн сургалт, Сумдын ЗДТГ-ын дарга нарын болон Багийн Засаг дарга нарын цэргийн сургалт, дайчилгааны бэлтгэл нөөцийн бэлтгэл үүрэгтнүүдийн сургалтуудыг холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай хамтран үр дүнтэй зохион байгуулж, биелэлт нь 87 хувьтай байсан аж. Энэхүү үзүүлэлт нь чамлахааргүй гэдгийг цэргийн штабаар орж гарж байгаа Аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтнууд хэлнэ билээ.

Харин энэ оны хувьд “Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сургалт, бэлтгэлийн чанар, үр дүнд анхаарч, сургалт явуулах орчин, нөхцөл, материаллаг баазыг нэмэгдүүлэх, аймгийн орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх, дайчилгааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах зорилго тавин ажиллаж байгаа аж. Дэлхийн даяар тархсан буюу шинэ төрлийн коронавирусын халдвартай холбоотойгоор багагүй ажлууд нь хойшлогдсон хэдий ч сургалт, бэлтгэлийг цахим, зайн гэх хэлбэрүүдээр

явуулахын зэрэгцээ аймаг, сум, багийн холбогдох хүмүүсийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр тасралтгүй хангаж байгаа талаар хурандаа Г.Нэмэхбаяр онцолсон. Үнэхээр “Хийх хүнд арга олддог, хийхгүй хүнд шалтаг олддог” хэмээх үг Завхан аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын хамт олонд тохирно. Учир нь шалтаг, зовлон тоочилгүй 2020 оны төлөвлөгөөндөө тусгагдсан олон ажлыг гүйцэтгэхээр зорин ажиллаж байгаа аж.

Цэргийн штабуудын гүйцэтгэх ёстой нэг чухал үүрэг бол хүүхэд, залуучуудад цэрэг, эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэхэд чиглэсэн ажлуудыг төлөвлөж, хэрэгжүүлэх билээ. Тэгвэл 2019 онд Завхан аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын хамт олон Засаг даргын ивээл дор таван сумын 10 гаруй Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг хамруулсан Цэрэг-спортын “Дөл” тэмцээн, Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ойн хүрээнд 24 сумын Ерөнхийн боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Халх гол танаа” сэдэвт эсээ бичлэгийн уралдаан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор явагдсан Бид Чингисийн үр сад, “Зөв тэмүүлэл-Эх оронч манлайлал” сургалтын шилдэг оролцогчдыг Дорноговь аймагт явагдаж байгаа Төмөр замын бүтээн байгуулалтын ажил, Зэвсэгт хүчний 013, 017, 150, 336, 7781, 7782 дугаар ангиудын үйл ажиллагаатай танилцуулах аялыг зохион байгуулж Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагаагаа сурталчилсан байна. Энд дурдсан ажлуудаас улбаалан цэргийн албанд явах, цэргийн мэргэжил эзэмших сонирхолтой хүүхэд, залуусын тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа тухай орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер, хошууч Г.Бавуудорж ярьсан юм.

Тэр бээр хүүхэд, залуусын цэргийн алба хаах хүсэл, сонирхол нэмэгдэж байгаа боловч эцэг, эхчүүдийн хандлага эсрэгээрээ байгаа талаар дурдсан. Учир нь цэргийн албаны талаарх цахим сүлжээнд тавигдаж байгаа мэдээ, мэдээлэл, ам дамжсан “хуучирсан” мэдлэг нь ихээхэн нөлөөлдөг аж. Иймээс эцэг, эхчүүдэд цэргийн албанд явснаар хүүхэд нь ямар боломж, бололцоонууд нээгдэх, Зэвсэгт хүчний ангиудын үйл ажиллагааны онцлог, алба хаах нөхцөлийн талаарх мэдлэг, мэдээлэл өгөх сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулах хэрэгцээ, шаардлага байгаа тухай ярьсан юм.

Цэргийн штабын бүтэц, орон тоо, хүн хүчний хувьд хязгаарлагдмал тул алслагдсан сум, багт хүрч ажиллана гэдэг нэг талаараа боломжгүй юм.

Тиймээс аймгийн цэргийн штабын ажлын багагүй хэсгийг нугалдаг хүмүүс бол орон нутгийн удирдах байгууллагын буюу Сумын ЗДТГ-ын дарга, ажилтнууд байдаг аж. Биднийг очих үеэр Улиастайд Завхан аймгийн 24 сумын ЗДТГ-ын дарга нар сургалтад сууж байсан бөгөөд зарим нэгэн төлөөлөлтэй нь уулзаж сэтгэгдлийг нь сонссоноо хүргэе.

Сонгино сумын ЗДТГ-ын дарга Ч.МЯНГАНБАЯР:

“Сумын ЗДТГ-ын дарга нар хуулиараа орон нутагтаа Батлан хамгаалах үйл ажиллагаа, хууль, тогтоомжийг сурталчлах, энэ чиглэлийн



бүхий л арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, гүйцэтгэх үүрэгтэй. Миний хувьд уг ажлыг 15 жилийн хугацаанд өөрийнхөө боломжийн хэрээр аймгийнхаа Цэргийн штабын хамт олонтой хамтран зохион байгуулж ирсэн. Орон нутагт батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа, цэргийн албаны тухай мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх төсвийг хангалттай тавьж өгмөөр байна. Учир нь цэргийн зарлан дуудах хуудсыг хуулиараа Багийн Засаг дарга нар өгөх ёстой байдаг. Гэтэл шатахууны зардал байдаггүй. Харин мэргэжлийн удирдлага, хууль журмынхаа хүрээнд Цэргийн штабынхан сайн ажилладаг. Сүүлийн жилүүдэд хүүхэд, залуус руу чиглэсэн цэрэг, эх орон ч үзэл, хүмүүжлийг олгох олон тэмцээн уралдааныг сурагчдын дунд тасралтгүй явуулдаг боллоо. Сурагчид хүртэл энэхүү тэмцээн, уралдаанд маш идэвхтэй оролцож байгаа ба тэмцээнд оролцож байсан хүүхдүүдийн эхнийх нь цэргийн албанд энэ хавар татагдсан.

Сантмаргаз сумын ЗДТГ-ын дарга С.СҮХБАТ:

“Улиастайн дивизийн 016 дугаар нэгтгэлийн 096 дугаар ангид 1984-1987 онд цэргийн албыг ахлах түрүүч цолтой, Эвлэлийн үүрийн дарга алба тушаалтайгаар хааж байлаа. Тухайн үед цэргийн ангид явагдаж байгаа нам, улс төрийн талаарх ухуулга, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулах, зурагт самбар хийх, “Улаан-од” сонинд мэдээ, мэдээлэл явуулах

зэрэг олон ажил хариуцдаг байв. Одоо бодоход байлдагч гэхээсээ илүүтэй конторын ажилтан шиг байж дээ. Намайг цэргээс халагддаг жил таван дивизийн 5000 цэрэг “Мандухай сэцэн хатан” кинонд тоглож, Элсэн тасархайд бүтэн сар болж Монгол Улсынхаа түүхэн уран сайхны бүтээлд оролцох завшаан тохиосон.

Сумын ЗДТГ-ын даргын ажлыг 23 дахь жилдээ гүйцэтгэж байна. Өөрөө гурван жилийн цэргийн албыг хаасны хувьд анх 1997 онд цэрэг татлага зохион байгуулаад “Зил-130” машинд 25 залууг ачаад 300



гаруй километр газар туулаад аймгийн комиссоор оруулж байсан саяхан мэт.

2018 онд батлагдсан “Төрийн албаны тухай” хуулийг дагаад цэргийн алба хаах хүсэл, сонирхолтой залуус их болж. Учир нь цэргийн алба хаагаагүй бол төрийн албанд ажиллуулахгүй гэдэг заалт нэлээн хөшүүрэг болсон нь мэдрэгддэг. Миний хувьд Сумын ЗДТГ-ын даргын үүргийг гүйцэтгэх хугацаандаа сумаасаа 230 гаруй залуусыг цэргийн албанд мордуулсан. Халагдаад ирж байгаа залуусаа ахмад дайчид болон цэргийн алба хааж байсан хүмүүсийн хамт баяр, ёслолын байдалтай угтаж авдаг. Энэ нь нэг талаар хүүхэд, залууст цэргийн алба хаах хүсэл эрмэлзлийг нь төрүүлдэг онцлогтой.

Нөмрөг сумын ЗДТГ-ын дарга Ц.АЛТАНТУЯА:



“Хуучин цаг шиг сургууль завсардах, мал дээр гарах гэхээсээ илүүтэй залуучууд эрдэм номын мөрхөө, гадагшаа ажил хийхээр явах зэргээр цэргийн насны хүмүүсийн тоо мэдэгдэхүйц цөөрсөн. Харин энэ жилийн хувьд цаг үеийн нөхцөлтэй уялдаанд цэрэг татлагын комиссоор орж байгаа хүмүүсийн тоо өссөн.

Цэргийн албанд хүүхдүүдээ явуулж байгаа эцэг, эхчүүдийн хандлага янз бүр байна. Тухайлбал, өөрсдөө хөөцөлдөж бариад явуулдаг сайшаалтай хүмүүс байхад, аль болох авч үлдэх арга, зам хайдаг нь ч бий. Зарим эцэг, эх хүүхдийг нь цэргийн албанд татагдах үед дургүйцэж байсан бол халагдаад, цэргийн эрдэмд суралцаж, биеийн болон сэтгэлийн хүмүүжил суугаад ирэхэд нь баярлалаа гэж хэлсэн тохиолдол цөөнгүй шүү. Мөн халагдаад ирж байгаа байлдагч нартай ар, гэрийнхнээс өмнө Сумын ЗДТГ-ын дарга нар уулздаг. Тэр үеэр залуус маань хэрхэн албаа нэр төртэй хаасан талаар ярьж, цэрэгт явуулсанд баярлаж талархаж байгаагаа илэрхийлдэг.

Сумын ЗДТГ, Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабтай

хамтран цэрэгт явах хүсэлтэй ч эрүүл мэндээр тэнцээгүй залуусыг эрүүлжүүлэх, цэрэгт яваад ирснийгээ ажил, хөдөлмөрт зуучлах ажлуудыг зохион байгуулдаг.

Алдархаан сумын ЗДТГ-ын дарга М.ЭРДЭНЭЦОГ:



“Сумын ЗДТГ-ын даргаар томилогдон ажиллаад 7 жил болж байна. Энэ хугацаанд Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний ойн баяраар сумынхаа төрийн албан хаагч, иргэдийн дунд цэргийн холбогдолтой уралдаан, тэмцээнийг тогтмол явуулж ирсэн. Энэ нь нэг талаараа цэргийн сургалт, бэлтгэл болдог сайн талтай юм.

Миний хувьд 2016 онд Зэвсэгт хүчний 123 дугаар ангид Бэлтгэл офицерын сургалтад хамрагдаж ЗХЖШ-ын даргын тушаалаар 2017 онд офицерын анхны буюу бэлтгэл дэслэгч цол хүртсэн. Эр хүн болж төрснийх тангараг өргөсөн офицеруудын эгнээнд багтсан нь бас л ховор завшаан юм. Тангараг өргөсөн бэлтгэл дэслэгч болохоор ч тэр үйл ажиллагааг хамгаалах салбартай холбоотой олон ажилд тэргүүн эгнээнд нь идэвхийлэн зүтгэхийг эрмэлздэг. Тухайлбал, жил 3-4 удаа багуудын хурлуудаар явж батлан хамгаалах салбартай холбоотой хууль, тогтоомж, журмыг танилцуулж гарын авлага, танилцуулах материалыг тараадаг.

Мөн Аймгийн Засаг дарга, Цэргийн штабуудтай хамтран жилд нэг удаа цэрэг эргэх ажиллагааг эцэг, эхчүүдийг хамруулан зохион байгуулдаг. Энэ нь цэргийн алба, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг орон нутагт сурталчлах том ажил болдог.

Тэлмэн сумын ЗДТГ-ын дарга С.БАТ-ЭРДЭНЭ:



“Монгол Улсын батлан хамгаалах салбарын хууль, эрх зүйн байдал сүүлийн жилүүдэд илүү сайжирч байна. Үүнийгээ дагаад цэргийн алба хаах сонирхолтой залуусын тоо ч жил бүр нэмэгдэх хандлага ажиглагдах болж. Тэрчлэн Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас жил бүр зохион байгуулдаг цэрэг-спортын “Дөл” тэмцээн ч үүнд томоохон дэмжлэг болдог. Тус тэмцээнд оролцох ахлах ангийн сурагчид цэргийн анхан шатны мэдлэг, мэдээллийг өөрсдөө бие даан судалж, хичээлийнхээ дундуур бэлтгэл сургуулилт хийж байгаа нь ямархуу түвшинд нөлөөлж байгааг илтгэнэ. Ахлах ангийн сурагчид, багш, эцэг, эхчүүдийн хандлага ч сайн байна.

Ахмад Э.ОЧХҮҮ

ХИЛИЙН ЧАНАДААС МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ МЭДЭЭЛЖ БАЙНА

БНӨСУ-д явагдаж байгаа “UNMISS” ажиллагааны Юнити мужийн зохицуулагч хатагтай Хироко Хирахараг ярилцлагынхаа зочноор урилла. Өдгөөгөөс бараг 20 жилийн өмнө буюу 2001 оноос НҮБ-тай ажил, амьдралаа холбосон түүнийг манай цэнхэр дуулгат дайчид, тэр тусмаа 2012 оноос хойш Өмнөд Судан улсад үүрэг гүйцэтгэсэн хэн бүхэн андахгүй. Бүсгүй хүнд ахадмаар асар их хариуцлагатай бөгөөд өндөр албан тушаалыг хашиж, монгол цэргүүдийг удирдлагаар ханган хамтран ажилладаг НҮБ-ын элч төлөөлөгч, арлын орны энэ бүсгүйн дотоод ертөнцийг бага ч атугай нээж, ажил амьдралынх нь замнал, алсдаа хэрхэх хүсэл мөрөөдөл, монголын тухай ойлголт, манай энхийг сахиулагчдыг хэрхэн үнэлж дүгнэдэг талаар ярилцсанаа уншигч Танаа хүргэе.



Хироко Хирахара: МОНГОЛ ЦЭРГҮҮД БАЙГААГҮЙ БОЛ МАШ ОЛОН ХҮНИЙ АМЬ НАС ЭРСДЭХ БАЙСАН

Таны бага насны дурсамжаар ярилцлага эхэлж...

-Би Япон улсын Осака хотод төрсөн. Айлын том охин. Бага насандаа маш сонинч, аливаа шинэ, содон зүйлсийг эрж хайн, нээж илрүүлэхийг эрмэлздэг охин байсан. Ялангуяа, гаднын улс орнуудын соёл, зан заншил, өв уламжлал, амьдралын хэв маяг ямар байдаг бол гэдэг талаар асар их сонирхдог, тэр ч утгаараа дэлхийн бүхий л улс орнуудад очиж үзэхийг хүсэж, мөрөөддөг байлаа. Япондоо ахлах сургуулиа дүүргээд дараагийн шатны сургуульд АНУ-д суралцсан, цаашлаад НҮБ-аар овоглодон нэлээдгүй улс оронд ажиллаж яваа маань миний хүсэл мөрөөдлийн биелэл гэж боддог. Нөгөө талаасаа хүсэл мөрөөдөл маань надад энэ бүх боломж, гарцыг нээж олгосон гэж бас болох юм.

АНУ-д ямар мэргэжил эзэмшсэн болон ажлын гараагаа хэрхэн эхлүүлж байсан бэ?

-АНУ-ын Олон нийтийн сургуулийг байгал, хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлээр 1997 онд төгссөн. Сургуулиа дүүргээд Токиод байрлах АНУ-ын цэргийн баазаас ажлын гараагаа эхэлж, тэнд мэргэжлээрээ 3-4 жил ажилласан. Мэдээж энэ хугацаанд ажлын дадлага, туршлага хуримтлагдсан, мөн мастера хамгаалснаар өөртөө итгэх итгэл маань ч нэмэгдэж гадагшаа гарч ажиллах тухай бодож эхэлсэн. Тэгээд л НҮБ-д ажиллах хүсэлтэй өгсөн. Хамгийн гол нь энэхүү зорилгоо биелүүлэхийн тулд би өөрөө бэлтгэгдсэн байж НҮБ-ын сорилт, шалгууруудыг давах ёстой. Тийм ч учраас маш их хичээл зүтгэл гарган өөрийгөө олон талаар дайчилж, үүнийгхээ үр дүнд чамгүй хүнд сорилтуудыг даван НҮБ хэмээх их айлтай ажил, амьдралаа холбосон шүү.

Хэзээнээс НҮБ-аар овоглодог болов. Түүнчлэн НҮБ-ын анхны томилолт таныг хааш нь хөтөлсөн бэ?

-НҮБ-д ажиллах гараагаа 2001 онд эхлүүлсэн. Тодруулбал, 2001-

баримталдаг гол зарчмаасаа бидэнтэй хуваалцаач?

-Ажлын талбарт үдэж өнгөрүүлсэн цаг хугацааны маань дийлэх нь буюу 80, 90-ээд хувь нь НҮБ-тай салшгүй холбоотой. Тийм учраас тус байгууллагынхаа

үнэт зүйлсийг баримталж, жанжин шугамаа болгон дагаж, мөрдөж ажилладаг. Үнэт зүйлс гэдэгт тухайн хүн хэн ч бай арьс өнгө, нийгмийн гарлаар ялгаварлахгүйгээр тэгш хүндэтгэх, хүний эрхийг дээдлэх зэрэг харилцааны соёлоос эхлээд бүхий л зүйл багтдаг. Мэдээж дараа нь “UNMISS” ажиллагааны мандатыг баримталдаг. Үүнээс гадна НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Тусгай төлөөлөгчийн гаргасан чиглэл зааварчилгааны дагуу ажилладаг даа.

Таныг маш амжилттай яваа эмэгтэй гэж бид ойлгодог. Зоримог, шийдэмгий, хүчирхэг гэх зэрэг олон үгийг танд зориулж бахархалтайгаар хэлэх байна. Үүний зэрэгцээ энэ хүртэл ажиллахад тань багагүй хүндрэл бэрхшээлүүд тулгарсан нь гарцаагүй, тэдгээрийг хэрхэн даван туулж байсан талаар тодруулмаар байна...

-Бурам мэт урмын үгсийг надад зориулж хэлсэнд маш их баярлалаа. Миний хувьд энд Засгийн газар түүний эсрэг хүчин, бүх хот, тосгодын удирдлагууд, энгийн болон цэрэг, цагдаагийн бүрэлдэхүүнтэй хамтарч ажилладаг. Тэр хэрээрээ маш олон асуудалтай тулгардаг. Тухайлбал, миний удирдлагад ажилладаг хүмүүсийн ар гэрт ямар нэгэн асуудал гарна, хоорондоо үл ойлголцож,

цагийн байдал хүндрэхэд монгол цэргүүд мандатад заагдсаны дагуу энгийн иргэдийг хамгаалах үүрэг гүйцэтгэхдээ маш зөв арга барилаар ажилладаг. Үүнийг би нүдээрээ харж байсан. Монгол цэргүүд үнэхээр зөв тактиктэй, асар богино хугацаанд зөв шийдвэрийг гаргаж чаддагаараа бусад орны энхийг сахиулагчдаас ялгардаг. Мэдээж хүн л юм чинь айдаг байж таарна, гэсэн хэдий ч энгийн иргэдэд аюул учирсан тохиолдолд монгол цэргүүд ямар ч эргэлзээгүйгээр мандатад заасан үүрэг биелүүлэхээр явдаг нь надад үнэхээр бахархуштай санагддаг. Үүнээс гадна тэд юманд баригдахгүйгээр чөлөөтэй сэтгэж, олон ажлыг зэрэг амжуулдаг. Тухайлбал, зөвхөн эргүүлийн үүрэг гүйцэтгээд л болчихдоггүй, иргэн-цэргийн харилцааны чиглэлээр хүмүүнлэгийн үйлсийг өрнүүлэх зэргээр чин сэтгэлээсээ ажилладаг. Тийм учраас би Монголын цэргүүдэд маш их баярладаг, тэдэнд бүрэн дүүрэн итгэдэг.

Монгол цэргүүдийн бусдаас ялгардаг онцлогийн талаар тодорхой жишээ дурдвал?

-Би энд нэг зүйлийг онцолъё. Ямар азаар “UNMISS” ажиллагаанд монголын эрэлхэг зоригтой, дайчин цэргүүд үүрэг гүйцэтгэж байна вэ гэж бодогддог. Хэрвээ энэ ажиллагаанд Монголын энхийг сахиулагчид байгаагүй бол асар олон хүний амь нас эрсдэх байсныг онцгойлон хэлэхийг хүсэж байна. Хамгийн сүүлийн тод жишээ л гэхэд өнгөрсөн 4 дүгээр сарын 11-ний өдрийн үйл явдал шүү дээ. Зөвсэглэсэн этгээдүүд олон улсын хүмүүнлэгийн байгууллагын ажилтныг хулгайлах оролдлого хийснийг монгол цэргүүд буун дуу гаргалгүй эрэлхээр таслан зогсоож бусад орны энхийг сахиулагчдад үлгэр дуурайлал болохуйц гавьяа байгуулж мандатад заагдсан үүрэг биелүүлсэн. Цөөнгүй жил монгол цэргүүдтэй хамтран ажилласан хүний хувьд энэ мэт олон жишээг гэрчилж чадна.

Монгол орны талаар та хэр мэдэх вэ?

-Надад талын монгол орон, тал шигээ уужим сэтгэлтэй монголчууд маш дотно санагддаг. Монголчуудыг дэлхий даяар Чингисийн монгол гэдгээр нь сайн мэднэ, миний хувьд ч ялгаагүй энэхүү тодотгоолоор нь мэднэ. Дээрээс нь би монголчуудыг сумогийн их аваргуудаар нь төлөөлүүлж мэднэ. Үүзона,

хариулна. Гэхдээ би монголд очиж байгаагүй, япон хүн шүү дээ. Дахиад нэг зүйл тодруулж хэлэхэд, манай хоёр орны ард түмэн маш ойролцоо, ижил чанартай гэж боддог. Яагаад гэвэл монгол хүүхдүүд хөх толботой төрдөг бол япончууд ч хөх толботой төрдөг. Тэгэхээр Япон, Монгол хүмүүс ойролцоо хүмүүс гэж хардаг.

Хүчирхэг хүний ард хүчирхэг гэр бүл байдаг гэж ойлгодог. Таны хувьд гэр бүлийнхэнтэйгээ хамт байх цаг хугацаа тун ховор байдаг болов уу?

-Тийм ээ. Үнэхээр гэр бүлдээ зарцуулах цаг хугацаа тун ховор. АНУ-д суралцаж байх явцаа мөн гэр бүлийнхэнтэйгээ хамт амьдрах боломжтой газруудаар ажиллаж явахад бол надад мэдрэгддэггүй байсан. Харин НҮБ-ын “UNAMID”, “UNMISS” ажиллагаанд ажиллаж эхлэх үедээ л гэр бүлээсээ хол байхын хэцүүг мэдэрсэн. Яагаад гэхээр зөвхөн утсаар л ярьдаг байсан. Одоогийнх шиг ийм хурдтай интернэт байсангүй, нүүр нүүрээ хараад ярьчих боломж ч байсангүй шүү дээ. Одоо бол арай өөр болсон. Миний хувьд хэдийгээр амжилттай ажиллаж яваа ч нэг л зүйлд харамсдаг. Тэр нь юу вэ гэхээр, манай гэр бүлийн настай хүмүүс нь өтөлж байна, хүүхдүүд нь маш хурдтайгаар өсч байна. Энэ бүгдийг хамт байж, харахгүйгээр өнгөрөөж байна гэдэг бол нэг бодлын надад харамсалтай санагддаг.

Ярилцлагынхаа эхэнд та айлын том охин гэдгээ дурдсан шүү дээ. Хэдэн дүүгийн эгч вэ? Түүнчлэн хэдэн хүүхдийн ээж вэ?

-Би гэр бүл зохиож, ээж болж амжаагүй яваа. Нэг эрэгтэй дүүтэй, тэр маань хүнтэй гэрлэчихсэн, гурван хүүхэдтэй. Миний хувьд аав, ээж, дүү нартаа буюу гэр бүлтэйгээ маш ойр дотно байдаг. Энэ хүмүүс бол миний хамгийн эрхэм хүмүүс дээ.

Залуу хойч үеийнхэнд та юуг эрхэмлэн захиж сургадаг вэ?

-Хүн бол өөрөө нийгмийн асар олон харилцаан дунд оршиж байдаг. Тэр хэмжээгээрээ цаг завгүй байх нь олонтоо. Хэдий тийм ч гэр бүлээ нэгдүгээрт тавьж, тэдэндээ цаг, зав гаргаж байгаарай, хамгийн эрхэм хүмүүс бол гэр бүл шүү гэж залууст хэлмээр байна. Нэлээд олон жил гэрээсээ хол хөндий явсан хүний хувьд үүнийг хамгийн түрүүнд хэлмээр байна. Дараа нь хүүхэд, залуус гар утсыг хэт их ашиглаж, хэтэрхий цахим орчинд байдаг болсон байна. Ингэснээр гэр бүлийн халуун



Асашёрюү, Харумафүжи, Хакухо гээд бүх сумочдыг сайн мэднэ. Харин монгол цэргүүдтэй мөр зэрэгцэн алба хааж эхэлснээсээ хойш монгол орны болоод монголчуудын тухай илүү сайн мэддэг болсон. Хэрвээ монголыг мэдэхгүй өөр нэгэн гадаадын хүн надаас “Чи монголыг мэдэх үү?” гэж асуувал би “Маш сайн мэднэ” гэж

дотно уур амьсгал, амьд харилцаа алдагдах дүр зураг харагдаж байгааг анхаарах хэрэгтэй. Үүнээс улбаалаад Монголын үндэсний гэрийг дурдахыг хүслээ, би монгол гэрийг маш сайн мэднэ. Гэр бүлээрээ халуун дотно уур амьсгалыг бий болгож, эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн хамгийн шилдэг сууц юм шүү.

Амралт чөлөөт цагаа хэрхэн яаж өнгөрүүлэх дуртай вэ? Таны сонирхол хобби юу вэ?

-Миний хобби ном унших. Гэсэн хэдий ч яг энэ цаг мөчүүдэд ном унших зав үнэхээр гаргахгүй байна. Яг үнэнийг хэлэхэд нэг сайхан ном уншаад тайван суумаар л байна. Мөн дуулах дуртай.

Таны дуулахыг сонссон. Үнэхээр сайхан дуулаг юм билээ...

-Үнэн гэж үү? /Инээв/ баярлалаа. Гэхдээ та бүхэн шиг сайхан дуулж чадахгүй байх аа. Монголчууд үнэхээр дууч ард түмэн гэдгийг би сайн мэднэ.

Таны цаашдын зорилго, хүсэл мөрөөдөл юу вэ?

-Хэрвээ би цэргийн хүн байсан бол магадгүй хурандаа, генерал болоод цаашид илүү өндөр албан тушаалд дэвших тухай бодож болох байсан байх. Гэхдээ энэ албан тушаал бол миний хувьд хамгийн оргил бөгөөд сайн хийж чадах ажил гэж бодож энэ ажлаар карьераа дуусгавар болгоно. Тэтгэвэртээ гараад гэр бүлтэйгээ төрөлх япон орондоо амар тайван амьдрахыг хүсэж байна. Япон улсад жуулчид их ирдэг, мөн адил гадаадын хүмүүс олноор очиж ажиллаж, амьдардаг. Тэр хүмүүст япончууд тийм ч ойр дотно байж, аливаа учрыг тайлбарлаж, хэлж ярьж чаддаггүй. Би тийм хүмүүст туслахыг маш их хүсдэг. Магадгүй би тэтгэвэртээ гарсныхаа дараа гаднаас ирсэн, хөлөө олж амжаагүй байгаа хүмүүст өөрийнхөө туршлага, сургамжаас хуваалцаж, туслах болно. Давуу тал маань гэвэл би англиар ярьдаг. Тийм учраас ямар ч хүндрэл гарахгүй байх. Би өнгөрсөн хугацаанд ажлын хүнд хэцүү, амьдралын хатуу хүтүү зүйлсийн талаар маш их туршлага хуримтлуулсан. Үүнийг зөвхөн өөртөө хадгалах биш бусдад түгээхийг хүсэж байна. Магадгүй хаана хэрэгтэй байна, намайг хэн дуудна, тэнд очиж ажиллахад бэлэн.

Ярилцлагынхаа төгсгөлд та манай сонины уншигч энхийг сахиулагчдад хандан юу хэлэх вэ?

-Үнэхээр монгол цэргүүдэд маш их баярлалаа гэдэг үг ч багадаа гээд байна. Би монгол цэргүүдээр маш их бахархдаг. Хэрэв та бүхэн өөрсдөөрөө бахархдаг бол бид та бүхнээс ч илүү та нараар бахархдаг шүү гэдгийг НҮБ-ын нэрийн өмнөөс дахин дахин хэлмээр байна. Монгол цэргүүдээ Та нар энд маш их хэрэгтэй шүү. Та бүхнийг энд байгаа хүмүүс харж байдаг шүү, итгэж найддаг шүү гэдгийг бахархалтайгаар онцлоод цэнхэр дуулгат монгол цэргүүддээ Олон улсын энхийг сахиулагчдын өдрийн халуун мэндийг дэвшүүлж, амжилт хүсье. Тэр тусмаа өнгөрсөн таван жилийн хугацаанд надтай хамтран үүрэг гүйцэтгэсэн бүх хүмүүсээр бахархаж байна. Бүгдээрээ буцаад ирээч ээ, хамтран ажиллаж гэж хэлмээр байна.

Цаг зав гарган ярилцсан танд маш их баярлалаа. Таны цаашдын ажил үйлсэд улам их амжилтыг хүсэн ерөөе...

-Олон улсын энхийг сахиулагчдын өдөр удахгүй тохиох гэж байна. Харамсалтай нь бид коронавирсийн тархалтын улмаас өмнөх жилүүдийнх шиг өргөн цар хүрээнд тэмдэглэж чадахгүй болсон. Гэсэн хэдий намайг Зэвсэгт хүчнийхээ хэвлэлээр дамжуулж энхийг сахиулагч монгол цэргүүдтэй уулзуулсанд туйлын баяртай байна. Ярилцлагынхаа төгсгөлд “UNMISS” ажиллагаанд монголын энхийг сахиулагчид байгаагүй бол маш олон хүний амь нас эрсдэх байсныг дахин хэлэхийг хүсэж байна.

Ахмад Д.МЭНДБАЯР



2003 онд Женев дэх НҮБ-ын Байгал орчны хөтөлбөрийг хэрэгжүүлэх оффист, 2003-2004 онд “UNICEF”-д НҮБ-ын Олон улсын хүүхдийн төлөө сангийн удирдах байгууллагад, 2004-2008 онд Либери дэх НҮБ-ын мандаттай ажиллагаанд Байгаль орчны зөвлөхөөр, 2008-2011 онд Хойд Судан улс дахь НҮБ-ын мандаттай “UNAMID” ажиллагаанд энгийн иргэдийн асуудал эрхэлсэн ажилтнаар, 2011-2012 онд Кипр улс дахь НҮБ-ын мандаттай ажиллагаанд энгийн иргэдийн асуудал эрхэлсэн хэлтсийн орлогч даргаар, 2012-2016 онд БНӨСУ дахь “UNMISS” ажиллагааны Зүүн секторын Торит мужийн зохицуулагчаар, 2016 оны хоёрдугаар сараас одоог хүртэл “UNMISS” ажиллагааны Юнити мужийн зохицуулагчаар ажиллаж байна.

Тэгэхээр НҮБ хэмээх энэ их айлын сүүлийн 20 жилийн түүхийг та бүтээлцсэн байна шүү дээ. Бахархалтай биш гэж үү?

-Тийм ээ. 20 жил гэдэг тийм ч богино хугацаа биш. Энэ хугацаанд НҮБ-аас надад өгсөн үүрэг, даалгаврыг амжилттай гүйцэтгэж, итгэлийг нь дааж яваадаа сэтгэл өндөр байдаг. Гэхдээ энэ ганцхан миний сайных биш, надад тусалдаг, намайг ойлгож дэмждэг олон хүний хүч, хөдөлмөр, сэтгэл зурх энд бий. Тэр тусмаа монгол цэргүүдийг илүү онцлохыг хүсэж байна.

Баярлалаа. Монгол цэргүүдийн талаар тусгайлан ярилцах учраас энэ тухай түр хойш тавья. Харин та ажилдаа

маргаан үүсгээд л орж ирдэг. Сая л гэхэд миний утас дуугарлаа шүү дээ, Маяом сууринд халдлага болж байгаа тухай мэдээ сонсогдож байна. Ингээд л бодохоор миний ажил маш хэцүү. Өдөр бүр л энэ мэтчилэн хүндрэлүүдтэй тулгарч байдаг. Ямар нэгэн бэрхшээл тулгараад бүр цагийн байдал хүндрэвэл бурхандаа залбирдаг.

Үүнээс гадна аль болох ажлаасаа жаахан ч гэсэн зай аваад найз нөхөд, хамтарч ажиллаж байсан ойр дотнынхонтойгоо утсаар ярих, чат бичих, эсвэл сайхан нам унтахыг хичээдэг. Тэгээд маргааш өглөө нь босоод маш сэргээгээр асуудлуудаа тунгааж зөв шийдвэрлэхийг эрхэмлэдэг. Аливаа бэрхшээлд шантрахгүй, өөрийгөө бас хүчилж зовоохгүй, стресстэхгүй давж гардаг арга энэ юм даа.

Та бол “МОНБАТТ”-ын хэд хэдэн ээлжийг удирдлагаар хангаж, хамтран ажилласан хүн. Тэр ч утгаараа манайхныг сайн мэдэх байх. Ер нь монгол цэргүүдийг хэрхэн үнэлж дүгнэдэг юм бэ?

-Тэгэлгүй яах вэ. Монгол цэргүүдийг би маш сайн мэднэ. Энэ тухай ярихаас өмнө эндэхийн нөхцөл байдлын талаар товчхон дурдъя. Өмнөд Судан улсын хувьд цагийн байдал тийм ч таатай бүс. Том хүн, хүүхэд гэлтгүй бараг бүгд зэвсэг хэрэглэдэг. Ямар нэгэн байдлаар үл ойлголцол, хулгай, дээрэм гарвал шүүд буудалцахад бэлэн ийм л хүмүүс. Үүгээр би юу хэлэх гэдэг байна вэ гэхээр, ямар нэгэн байдлаар

СОНИНЫ ХУУДАСНААС ...

1987 оны 7 дугаар сард би “Улаан од” сонинд дадлага хийхээр очлоо. Эхний өдрийн үдийн цайны цагаар гурван хүүхэнтэй хамт гарч хороололд нэгнийд нь очихоор троллейбусаар явав. “Од” кино театрын буудал өнгөрч явтал хоёр хүн зорчигчдын билет шалгалаа шүү. Тэр үед билетийг урьдчилж аваад зориулалтын хайрцагт шургуулж цоолдог байсан юм. Т.Ганди, Л.Туяагэрэл хоёр “Улаан од”, Б.Энхтуяа “Залуучуудын үнэн” сонины сурвалжлагчийн үнэмлэх үзүүлээд урагш явлаа. Би билет аваагүй байсан юм. Сонсогчийн үнэмлэхийг яаж тоох вэ, 30 төгрөгөөр торгуулж билээ. Т.Гандигийнд очиж, хүүхнүүдийг дайлаад буцахдаа би хүнээс билет худалдаж аваад явсан ч замд шалгагч таарсангүй. Үүнийг сөхдөгийн учир би Т.Гандийг дурсаж байгаа ухаантай юм.

Сэтгүүл зүй бол амьдрал, үнэн хоёрын нэгдмэл бүтээл гэх нь бий. Бас нэг бичигдээгүй хууль байдаг нь сэтгүүл зүйг онол биш бичлэг цогцлоодог гэх. Энэ нь ч үнэний хувьтай. Наяад оны дунд үед төвийн бараг бүх хэвлэлийн эрхлэгчийн албыг сэтгүүлч биш мэргэжилтэй хүмүүс хашиж байсан нь залуухан сэтгүүлч миний гайхлыг төрүүлж билээ. Тэр үед 400 гаруй сэтгүүлч байсан гэдэг. Сэтгүүлч биш атлаа сэтгүүлчдийн дээр гарна гэдэг өнөө бичлэгээрээ ялгарч, тодорсны илрэл л дээ. Бичлэгээрээ л ялгардаг нь сэтгүүл зүйн дотоод шаталтын мөн чанар учраас хаана бичлэг чамбайрна тэнд сэтгүүл зүйн гал тогоо сайн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна гэсэн үг. Монголын сэтгүүл зүйд хоёрхон “школь” бий гэх. “Школь” гэдэг нь арга барил, сэтгүүлчдийн ур чадварыг илтгэж буй үнэлэмж юм. “Үнэн” сонины школь, “Улаан од”-ын школь. Энэ хоёр сонины гал тогоонд чанагдсан сэтгүүлчид цаг үедээ эрс ялгарч байсан. Могой гурав таслагдвч гүрвэлийн дайтай гэдгийг баталж, өдгөө ч чамбай сэтгүүлчдийн зарим нь тэр шкولوудыг дамжсан нөхөд л байна шүү дээ. 1980-аад оны сүүл хагаст “Улаан од” сонины содон сурвалжлагчийн нэг нь Т.Ганди байлаа. Цэргийн сонины хоёрдахь эмэгтэй сурвалжлагч. Түүнээс өмнө сэтгүүлч Д.Бямбасүрэн эгч цэргийн сонинд байсан, 27 жил ажиллахдаа ихэвчлэн захидал харилцааны албыг хариуцаж байлаа. Т.Ганди яагаад содон сурвалжлагч байсан бэ, баахан эрчүүдийн дунд ганц эмэгтэй нь байсан учраас гэвэл эндүүрэл. Түүний бичлэгийн өнгө аяс, нэн ялангуяа эрчүүдийн нүдэнд төдийлөн өртдөггүй, байдаг л юм гэсэн жижиг атлаа алсдаа уршиг дагавартай жижиг биш алдаа, эндэгдэл бүр цаашилбал хэвшил дадал болсон цэргийн албаны гажуудлыг маш сайн бичдэгт байсан юм. Т.Ганди “Улаан од” сонинтой хэрхэн холбогдов. 1984 онд тус сонины 60 жилийн ойгоор редакцынхан бүрэн бүрэлдэхүүнээрээ татуулсан гэрэл зурагт Т.Гандигийн зураг байдаггүй юм. Цэргийн сэтгүүлч Б.Цэдэн 1985 онд нийслэлийн 75 дугаар сургууль төгссөн хүн. Тэр бээр ярихдаа, Т.Ганди манай сургуульд Эвлэлийн хорооны дарга байсан гэсэн шүү. Хэзээ ажилд орсон нь чухал биш, хэрхэн бичсэн нь л чухал. 1986 оноос л “Улаан од”-ын хуудаснуудыг Т.Гандигийн өвөрмөц бичлэгүүд чимэглэж, цэргийн уншигчдын дунд мэргэжлийн ур чадварын шинэлэг агаарыг бий болгосон байдаг.

Сэтгүүлч гэдэг мэргэжлийн ард хэд хэдэн мэргэжил дагаж явдаг жамтай. Үнэнийг бичих, энэ бол хүн чанар, зориг зүрхтэй байхын оршин тогтнох тэнхлэг нь юм. Хэний ч өмнө үнэнийг хэлнэ гэдэг шударга шүүгчийн зан чанар. Хар, цагааныг дэнсэлж чадна гэдэг прокурорын ажил шүү дээ. Энэ бүхнийг нэгэн сэтгүүлч цогцоор нь хадгалж, илэрхийлж бичнэ гэдэг амаргүй, ховорхон юм. Т.Гандид эдгээр чанар цогцоороо шингэсэн учраас л мэргэжил нэгт нөхдөөсөө эрс ялгарч, үнэний дуу хоолой болон уншигчдад таашаагдаж байсан билээ. Сэтгүүлч хүнд өөр нэг чанар байж л гэмээ нь сонины хуудсанд, уншигчдын хүрээлэлд оршин тогтнодог. Энэ нь ямар ч тохиолдолд, хэний ч бичсэн зөвхөн үнэнийг л бичих, мэргэжлийнхээ өмнө эзэн байх чадвар юм. Бичсэнийхээ төлөө шоронд сууж, шороонд булагдах байсан ч гагцхүү үнэнийг л бичих. Ийм чанар тэр бүр захын сэтгүүлч

гэгдэх мэдээ бичээчид байдаггүй юм. Ийм чанар хүн чанартай ихэр учраас цөөн сэтгүүлчдэд л байдаг учиртай. Энд би бичлэгийн ур чадварын тухай яриагүй байна. Үнэнийг бичихэд ур чадвар өөрөө дагалддаг. Хуурамч магтаал бичихэд ур чадвар гардаггүй. Т.Ганди бичлэгийн өндөр ур чадвартай сэтгүүлч, яагаад гэвэл тэр бээр үнэнийг л бичдэг

дутаагаас л өнөө цагийн сэтгүүл зүйн мөн чанар, нэр хүнд шалдаа буусныг хүлээн зөвшөөрөхөөс бултах булангүй болсон шүү дээ. Аливаа сэтгүүлчид бичлэгийн онцлог гэж байх. Т.Гандигийн бичлэгийн онцлог нь ердөө л гарчиг. Сайн гарчиг өгүүлэмжийнхээ жаран хувийг даагаад гардаг гэх бичигдээгүй онолыг баталж чадсан цөөн

морилно уу” гэсэн мэт нээлттэй, харуул, манаач ч харагдсангүй. Хамт явсан яамны офицер намайг цэргийн байр руу оруулж өгөөд, цэргийн гал тогоо, штаб хавийг эргэхээр явав. Цэргийн байранд зурагт үзэж байсан хэдэн цэрэгтэй яриад сууж байтал жижүүрийн офицер ороод ирлээ. Энгийн хувцастай намайг танихгүй байна. Ингээд л нөгөө

зохилтой хэмээн үзлээ. Бусдын үгээр хооллож байна гэж намайг зэмлэвэл зэмлэнэ л биз. Гар барьсны бугуй бариад өөр нэг сэтгүүлчийн бичсэнийг бас хавсаргаа. Эмэгтэй хүний нүдээр түүний бичлэг хэрхэн харагдах вэ. “Т.Ганди улс төрд зоримог хөл тавьсан. Тэр угаасаа л аливаа шатан дээр дутуу, эсвэл хальт гишгэдэггүй хүн. Тууштай,

Т.ГАНДИ БА “УЛААН ОД”



“Улаан од”-ынхон редакцияраа Улан-Үдэ хотод зочилсон нь. 1990 он

учраас тэр. Бусдын таашаалд нийцүүлж бичих, хэн нэгэнд долгигонож бялдуучлан бусдын үг, зааврыг биелүүлэн бичлэгтээ тусгах, захиалгаар бичих зэрэг нь сэтгүүлч хүний хувьд мөхөл юм. Ийм мөхлийн эсрэг дархлаа нь ердөө л үнэнийг бичих. Т.Ганди бид хоёрыг уншигчид сэтгүүлч гэж нэрлэдэг юм. Үнэнийг л бичдэг учраас тэр л дээ.

Анги, байгууллагад сониноос сурвалжлагч иржээ гэсэн яриа гарахад, өнөө Т.Ганди нь ирсэн үү гэж эмээнгүй асуудаг дарга, офицер олон байсан даа. Ялангуяа дарга нар. Эмэгтэй хүнээс эмээдэг офицер гэж хаа байх вэ, харин хаанаас үнэнийг ухаж гаргаад дэлгэх бол л гэж бэргэдэг байв шүү дээ. Үнэний өмнө хэн хулчийдаг вэ гэвэл дарга нар. Т.Ганди нэг удаа, хамаг булхайг таригч нь дарга нар л байдаг гэж хэлсэн удаатай. Т.Гандиг би магтаж гэж байгаа юм биш, надаар магтуулаад байх ч хүн биш. Үнэн ба Т.Ганди хоёрыг л бичиж байгаа царай минь энэ. Монголын уншигчдын өмнө танигдсан сэтгүүлч гэвэл би биш харин Т.Ганди маань. Би түүнийг улс төрчийнх нь хувьд бичээгүй сэтгүүлчийнх нь хувьд хэдэн үг хэлж байгаа юм. Надад ийм эрхийг нам, засаг биш уншигчид өгсөн юм шүү. Төр, засаг түүний авьяас чадвар, үнэнч хөдөлмөрийг үнэлж шагнасан. Сүхбаатарын одон түүний энгэрт сайхан зохисон доо.

Сэтгүүл зүй бол онолд ягштал тулгуурлаж, хэвшмэл хэллэг, нэг загварын хайрцагт захирагддаг үлбэр бичлэг биш. Сэтгүүлчийн нүд, эрэл хайгуул нь амьдралын талбар байдаг. Сайн сэтгүүлч өрөөнд суудаггүй гэсэн онол болоод практикийг бүтээлчээр хэрэгжүүлж чадсан. Өөрөөр хэлбэл амьдралын гүнээс үнэнийг өгүүлж, өрөөнд биш амьдрал дунд явдаг сэтгүүлчийн нэг бол Т.Ганди. Өрөө нь ихэнхдээ эзгүй л байх. Харин олборлосон мэдээ, баримт, сонирхол татахуйц адал явдал, үнэн үйл, нууцлагийг илэрхийлсэн санаа нь уншигчдад хүрэхээсээ өмнө өдөржин өрөөнд суугаад үзгээ мэрэхээс холгүй санааширч үлдсэн хэдэн сурвалжлагч нарынхаа гайхал, атааг зэрэг төрүүлэх. Түүний бичсэн нийтлэл, сурвалжлага бүр уншигчдын сонирхлыг татаж, үнэн гэдэг үзэгдэж харагддаггүй гайхал болорын талст адил гялалзаж харагддагаас л нэрт соён гэгээрүүлэгч М.Цэдэндоржийн хэлсэнчлэн “аймхай хүн уншаа аймаар үнэн” байдагт л түүний сэтгүүлчийн ур чадвар, эр зориг оршдог байлаа. Үнэнийг үнэнээр нь илэрхийлэхэд уянгын халил, бичлэгийн ур чадвар, сайн найруулга энэ тэр шаардлагагүй, ердөө л зориг, зүрх хэрэгтэй. Энэ зориг, зүрх тэр бүр сэтгүүлчдэд

сэтгүүлчийн нэг нь Т.Ганди юм. “Гараж нураасан ганц үсэг”, “Захирагчийн захирагч”, “Нударга зангидсан нуугдмал хурандаа”, “Буутай мөртлөө хүлээтэй юм шиг зодуулдаг гэнэ”, “Хотоороо сүйрэх аюул”, “Хагацал буюу хаягдмал хүмүүс”, “Араншингийн өвчин аюултай”, “Накамура сан гэж хэн бэ”, “Мистер Флиний аялал өндөрлөв” зэрэг гарчигтай нийтлэл цагтаа цэрэг арми, улс орон даяар дуулиан дэгдээж үнэнийг илчлэхийн үлгэр жишээ болж байсныг санах уншигчид элбэг шүү дээ. Т.Ганди “Ардын эрх” сонинд ажиллахаар явсны дараа л манай редакцын хэдэн хар юм түүнийг үгүйлж эхэлдэг байгаа. Ганц хүүхэнтэй байгаад хэдүүлээ хоцорсондоо биш гайхалтай эрэл хайгуултай, ганц өгүүлбэр нь нүдэнд содон тусдаг нийтлэл, сурвалжилга үгүйлэгдсэнээс л тэр. Т.Гандигийн бичлэгийг сонины дугаар давсгүй хоол шиг санагдаж байсан үе бий юм шүү. Цэргийн сонинд Т.Гандигийн орон зай үнэхээр үгүйлэгдэж, хэн маань яаж бичиж тэр орон зайг нөхөх вэ гэдэг том асуудалтай тулгарч байлаа. Биднээс түүний бичлэгийн орон зайг уншигчид нэхэж байсан тийм зурвас үе байлаа даа. Энэ нь угтаа Т.Гандийг биш үнэнийг нөхөж буй хэрэг байлаа. Анги, салбарт сурвалжлагч ажлаар очиход захирагч, дарга нар түүнийг сураглаад ирээгүй гэхэд инээмсэглэнэ. Ийм инээмсэглэл нь үнэнийг эрж ухаж төнхөж, гайтуулах хүнгүй гэсэн санааг илтгэнэ. “Ардын эрх” сонинд Т.Гандигийн бичсэн “Модон галай” гэсэн нийтлэл хэвлэгдсэн юм. Ердийн хархны тухай л даа, гэхдээ гарчиг нь гайхалтай. Сурвалжлагч С.Баярмөнх “Энэ нийтлэлээ манай сонинд өгчигүй дээ, тэгсэн бол сонины нэр хүнд суга өсөхгүй юу” гэж цагаахан атаархаж л байсан юм даг.

УИХ-ын гишүүнээр дөрвөн удаа сонгогдож Байнгын хорооны дарга, төрийн сайд, элчин сайдын алба хашиж явсан улс төрчийнх нь замналыг би бичиж чадахгүй ээ. Энэ нь над мэт тал бичээчид ахадсан ажил болох нь ойлгомжтой. Ийм өндөр алба хашиж, зав чөлөөгүй явсан үедээ Т.Ганди цэргийн сонин руу анхаарал хандуулж, бяцхан дурсамж бичиж байсныг 10-аад жилийн хойно уншигчдад толилуульж байна.

“Соёмбо” сониныхоо уншигчдад сонирхолтой байх болов уу гэж нэг хөгтэй юм дурсъя. Нэг үе манай сонины редакт БХЯ, Улс төрийн газартай хамтран “Жижүүр захирагчийг орлоно” гэдэг сэдвээр анги, салбарт шалгалт хийдэг байв. Би Хужирбуланд байрлах батальонд очлоо. Ангийн үүд хаалга “Тавтай

хууран хэсэж явдаг хүүхнүүдийн нэг гэж бодсон юм байлгүй тачигнаж гардаг байгаа. Бараг заамдаж аваад гаргах нь ээ. Гэтэл ашгүй хамт явсан офицер маань ирж, жижүүр ч шалдаа бууж билээ. Шинэхэн сурвалжлагч, залуухан охин явсан болоод ч тэр үү, их чочирдож, буруутай юм шиг таг дуугүй зогсож байсан маань санаанаас ер гардаггүй юм”

Тэрбээр ийм сэтгүүлч явж, цэргийнхний дунд сэтгүүлчийн хөдөлмөрийг ангийн хашаанаас гаргаж чадсан нэгэн. Аливаа хүний үнэн мөр гэдэг цагийн салхинд элэгддэггүй бололтой. Өдгөө Т.Гандигийн тухай, түүний бичлэгт өртөж шийтгүүлж явсан талаар, хэрийн салхинд хаяа нь дэрвэсэн ногоон майханд өвдөглөн суугаад, дарийн утаа үнэртсэн сурвалжилга бичихэд нь хамт байсан тухайгаа наяд оны офицерууд инээлдэж хөхрөлдөн ярьсаар л байдаг.

Т.Ганди УИХ-ын гишүүнээр ажиллаж байхдаа “Авьяас бол бурхны хишиг. Хэн ч уудлаад, булаагаад авчаж чаддаггүй ганц зүйл. Сэтгүүлчээр ажиллахад авьяас мэдрэмж хоёр аав ээж шиг ойрхон байдаг зүйл дээ. Нэгэнт энэ мэдрэмжийг эзэмшиж чадсан юм хэзээ нэгэн цагт үргэлжлүүлээд уран бүтээлээ хийгээд явахад зүрх сэтгэл минь бэлэн байдаг болохоор улс төрд орсондоо нэг их харамсаад байдаггүй. Гэхдээ би сэтгүүл зүйд тууштай хүчин зүтгэсэн бол тэргүүлэгч нь байх л байсан” гэж хэлснийг нэрт сэтгүүлч, орчуулагч А.Баасандорж тэмдэглэн авчээ. Ирээгүй биш ирээд буцсан хэзээ нэгэн цагт Т.Ганди манай сэтгүүл зүйн тэргүүлэгч, түүчээ нь байсан билээ.

Би Т.Гандигийн “Ягаан болорын хаан” тэмдэглэлийн номыг уншаад түүнийг арай л наахнуур ойлгож явсандаа хүлцэл өчмөөр санагдсан. Чансаатай, чадварлаг сэтгүүлч, нийтлэлч гэдгийг нь мэднэ л дээ. Гэхдээ ингэж уран дэгжин, хуурамчгүй үнэн, үзтэл ил гоо сайхантай бичнэ гэж санасангүй. Амьдралын эрэн мяраан сүлжилдсэн олон өнгөнд үзгээ дүрээд авсан юм шиг тод томруун туурвина гэж яаж санах вэ.

Түүнийг сэтгүүлч, зохиолч биднийхээ дунд өнхөрч, босож явахгүй яагаа вэ дээ гэж жаахан ганасхийв. Гэвч тэр биднийхээ дунд л байж. Хэдийдээ Т.Ганди үндэснийхээ хэлний аар амтлахгүй өөртөө хав халуунаар нь шингээчихсэн юм мэдэхгүй. Т.Гандигийн алтны “нинжа” шиг тоншуур ур хийгч, олж хатгасан мэргэн саналга гайхалтай” гэж Соёлын гавьяат зүтгэлтэн, Нацагдоржийн шагналт зохиолч До.Цэнджавын бичсэнийг дамжуулсан нь би хэлэхээс илүү

аливаад амархан автдаггүй зантай Т.Ганди улс төрд ч гараар онгойдог цоож шиг дэл сул амьтан явсангүй. Би л лав үүнийг бардам хэлнэ. Тэр манай улс төрийн хүлээн зөвшөөрөгдсөн хатагтай. Хамгийн гол нь тэр ажлаа хаяагүй юм байна. Юун улс төрд булаагдах. Улс төр түүний авьяасыг нь ч, мэргэжлийг нь ч булааж чадаагүй юм байна. Тэр парламентад ажилласан он жилүүддээ ч сэтгүүл зүйн “тэмдэглэл” хэмээх торгон зүйлийг тэрлэсээр, тээсээр ирсэн байна. Хамгийн сонин дүрүүдийг бүтээж, хамгийн анзаарагдамгүй юмыг ажиг, тэр бүртээ нээлт болгон бичиж ирснийг уншигчид мэдэрсээр байгаа юм.

Нийтлэлүүд нь үнэхээр “гаатай” бичлэгтэй юм, сурвалжилгууд нь хүний сэтгэлийг хөдөлгөсөн уртай, дүртэй, мэдрэмтгий, нарийн бичлэгтэй. Баримтыг авьяастай сэтгүүлч л баяжуулж чаддаг. Авьяасгүй, ердийн нэг гөлгөр, мөлгөр сэтгүүлчид бол юун хүний сэтгэлийг хөндөх байтугай хамаг урам хугалж, уур бухимдал л төрүүлээд дуусдаг шүү дээ” хэмээн Соёлын гавьяат зүтгэлтэн, нэрт сэтгүүлч Б.Ганчимэг бичсэн байгаа юм. Бусдын будаа амттай гэдэг энэ дээ. Одоо өөрийнхөө будааг нэмэртлээ. Т.Ганди маань уран зохиолын төрлөөр “Эрэл”, “Аянга” гэсэн уран сайхны хоёр кино зохиол бичиж дэлгэцэнд гаргасан ч зохиолчдын хороо энэ, тэрээр гүйгээд байдаггүй даруухан зохиолч. “Ягаан болорын хаан”, “Европчууд аймхай хүмүүс” гэсэн сэтгүүл зүйн номууд нь гарчгийн хувьд ч, горь хувьтай гэгээн үнэнийг илчилсний хувьд ч нэн сонирхолтой бүтээлүүд юм. Цэргийн сэтгүүл зүйд нээлт болж бичсэн бүтээлүүд нь түүнийг цэргийн сонины хэдэн хар нөхдийн магнайд духдуулсан титэм мэт гэрэлтүүлсэн билээ.

Зав чөлөө багатай, төрийн ажлын төлөө зүтгэж, үзэгдэж харагдах нь ховор үедээ ч Т.Ганди цэргийн сонины босгоор бол урилгатай ч, урилгагүй ч алхана. Яагаад гэнэт ороод ирвэ гэхэд “Хэвлэлийн будаг, сонины цаасны үнэр үгүйлээд, бас та нарыг яаж будилж, нооргоо хэд дахин хуулж, эрхлэгч нь улаан эрзэн болгосныг харх гэж ирлээ” гээд хөхөрнө. Редакцадаа ийм өөриймсөг сэтгэлээр хандана. Цэргийн насны залуусын эрүүл мэндийн талаар бичсэн миний нийтлэлийг харж байгаад Т.Ганди гарчгийг нь улаан балаар дарж “Авдар шиг цээжтэй эрчүүд байсан гэдэг үнэн үү” гээд биччихэж билээ. Гэрэлтээд л явчаж байгаа юм. Уг нь би “Залуус аа, эрүүл мэнддээ анхааръя” гэсэн гарчиг бичсэн байв. Үнэхээр үлбэр, байдаг л хэдэн үг байсан байгаа биз. Өөрийн гэлтгүй бусдын бүтээлд ингэж элгэмсэг хандана гэдэг тэр бүр сэтгүүлчид байдаггүй чанар л даа. “Соёмбо” сонины 95 жилийн ойн баярын хурлын индэр дээрээ “Инженерийн цэрэг” төрийн бус байгууллагын тэргүүн, бэлтгэл дэд хурандаа Ариунболд “Зүүнбаян 10 мянга гаруй цэрэгтэй ид булжигнаж байсан үе. Ангиудын захирагч нар атаатан дайснаас биш хоёрхон зүйлээс айна. Сайд ирэхэд айна, сониноос Т.Ганди ирэхэд айна” гэж тухайн цагийн үнэнийг үнэнээр нь хэлж байлаа. Сэтгүүлч хүний мөн чанар мэдээ бичих биш. Сэтгүүлч хүний мөн чанар нь мэдэн будилалгүй харыг хар, цагааныг цагаан гэж л бичих. Энэ шалгуурт тэнцэх сэтгүүлч монголд хуруу дарам цөөн, хуудуугүй үнэнийг хэлэхэд шалчгар хүн шивнэж хэлмээр тийм цөөхөн бий. Тэдний нэг нь Т.Ганди.

Цэргийн мэргэжлийн сэтгүүлч, бэлтгэл дэд хурандаа П.БАТНАЙРАМДАЛ

Шүлэг: Г.Баатарнум
Хөгжим: Т.Насанбуян

ЭНХИЙН ҮЙЛСЭД МОНГОЛ ЦЭРГҮҮД

Эзэн Чингисийн хийморьтой
Эрэлхэг Монголын хөвгүүд
Элгэн халуун сэтгэлээрээ
Эх орноосоо мордсон юм аа
Миний Монголын хөвгүүд
Морьтойгоо дэлхийг туулсан юм
Миний Монголын цэргүүд
Энхийн үйлсийг зорьсон юм
Саран ээжийн бүүвэйлсэн
Сайхан Монголын хөвгүүд
Хүнлэг ариун сэтгэлээрээ
Хүмүүний төлөө тэмүүлээ
Дахилт:
Эцэг тэнгэрийн заяатай
Эрэлхэг Монголын хөвгүүд
Гал бадарсан сэтгэлээрээ
Тив дэлхийд дуурссан юм
Дахилт:

Шүлэг: Б.Нямаа
Хөгжим: А.Алтансүх

ЦЭНХЭР ДУУЛГАТ МОНГОЛ ЦЭРЭГ

Жанжин тугандаа ёслосон
Жагсаал дундаа жигдэрсэн
Хүннү гүрнээс замналтай
Хөх тэнгэрээс зарлигтай
Дахилт:
Цэнхэр дуулгат Монгол цэрэг
Энхийн төлөө алхаж явнаа
Хүчирхэг гүрнүүдийн дайчидтай
Мөр зэрэгцэн алхаж явна аа
Хар сүлдэндээ залбирсан
Хийморь золбоо нь бадарсан
Эзэн Чингисээс адистай
Ижий аваас авшигтай
Дахилт:
Алтан соёмбодоо сүсгэлсэн
Ариун үйлсэд зүтгэсэн
Аравт цэргээс улбаатай
Ардын хүүгийн гялбаатай
Дахилт:

Шүлэг: Р.Өнөржаргал
Хөгжим: О.Эрдэнэцог

ЭНХ ЦАГИЙН ЦЭРГҮҮД

Тасаг салаагаар эгнээ жигдлээд
Тангараг өргөж тугандаа мөргөөд
Дээдсийн суутай алдраа дуурсгахаар
Дэлхий дахинд мордсон цэргүүд ээ
Дахилт:
Ханагар орныхоо энхийн нарыг
Хатан дэлхийнхээ эвийн баганыг
Мөрөн дээрээ өргөж яваа
Мөнхийн тангарагтай дайчин цэрэг ээ
Сүүгээ дээжилсэн ээждээ үдүүлээд
Хүүгээ тэвэрсэн гэргийгээ үнсээд
Хайртай бүхнээ сэтгэлдээ тээгээд
Хат суусан дайчин эрчүүдээ
Дахилт:
Олон орныхоо цэрэг дайчидтай
Оюун бодлоор нэгдэн нөхөрлөөд
Ариун энхийн төлөө зүтгэсэн
Андгай нэгтэй дайчин эрчүүдээ
Дахилт:

Шүлэг: Б.Хаш-Эрдэнэ,
Хөгжим: Х.Бямбахишиг

ЭНХИЙН ЦЭРЭГ

Эзэн Чингисийн алдрыг мандуулсан
Эрэмгий зоригт Монгол цэргүүд
Эх орныхоо нэрийг өргөсөн
Энхийн үйлсдээ зүтгэж явнаа
Дахилт:
Эзэн Чингисийн Монгол цэргүүд
Эвслийн хүчний зоригт дайчидтай
Эх дэлхийн энхийн төлөө
Энхийг сахиулж хамт явна
Аранзал тугаа дээдлэн шүтсэн
Арабын цөл, Афганы улсад
Арьс өнгөөр хэнийг ч ялгалгүй
Амгалан энхийг бэхжүүлж явна
Дахилт:
Цэлмэг тэнгэрийн өнгийг дээдэлсэн
Цэнхэр дуулгатай цэрэг эрчүүд
Алтан соёмбот тугаа мандуулсаар
Алдар нэрээ дуурсгаж явна
Дахилт:

Шүлэг: СТА Р.Өнөржаргал
Хөгжим: СТА Б.Мөнхжаргал

ЖАГСААЛЫН ЧИМЭГ ДАЙЧИН БҮСГҮЙ

Сүүтэй энгэртээ алдрын одонтой
Дуутай жагсаалдаа энхрийнхэн дүртэй
Бүрэн заяатай улсынхаа төлөө
Бүтэн амьдралаа зориулж зүтгэсэн
Дахилт:
Жаргалтай орны жавхаатай бүсгүй
Жагсаалын чимэг дайчин бүсгүй
Тэнгэрлэг эрстэйгээ мөр зэрэгцэн
Тив дэлхийгээ хамгаалж явна аа
Нартай хорвоодоо хатан заяатай
Нарлаг монголдоо хайрын тангарагтай
Бүүвэйн дуутай үрсийнхээ төлөө
Бүхий л сэтгэлээ зориулж зүтгэсэн
Дахилт:
Сартай шөнөөр соргог манаатай
Сайны төлөө мөнхийн харуултай
Цэнхэр гарагийнхаа энхийн төлөө
Цэцгийн дэлбээг ч хайрлаж өмгөөлсөн

ЦЭРЭГ-УРАН ЗОХИОЛ

Шүлэг: Г.Баатарнум
Хөгжим: Р.Ганбат

МӨН Ч ЗАЛУУХАН БАЙЖ ДЭЭ

Тэр л жилийн тэр нэг өдөр
Тэнцэж торнисон нутгаа орхиод
Эрэлхэг дайчин нөхдийнхөө хамт
Энхийг сахиулахаар мордсон
Хууз сахалтай эрчүүд Гивлүүр нөмрөгтэй хүүхнүүд
Лалын шашны сүм хийд Ягааран улайссан тэнгэр
Одоо ч бидний сэтгэлд тодхон
Мөн ч залуухан байж дээ
Тэсэрч дэлбэрэх айдас хүйдэс
Тэнд ч энд ч буун дуу тачигнаад
Энхрий ханийн эрвэгэр үрээ
Элгэндээ, сэтгэлдээ байнга үгүйлдэгсэн
Хууз сахалтай эрчүүд Гивлүүр нөмрөгтэй хүүхнүүд
Лалын шашны сүм хийд Ягааран улайссан тэнгэр
Одоо ч бидний сэтгэлд тодхон
Мөн ч залуухан байж дээ
Орон орны цэрэг эрчүүд
Орсон ч гарсан ч хамтдаа бидэнтэй
Халуун амиа зарим нь алдсан ч
Хожмын гавъяа нь түүхэнд мөнхөрсөн юм
Хууз сахалтай эрчүүд Гивлүүр нөмрөгтэй хүүхнүүд
Лалын шашны сүм хийд Ягааран улайссан тэнгэр
Одоо ч бидний сэтгэлд тодхон
Мөн ч залуухан байж дээ

Шүлэг: Д.Гриш
Хөгжим: Ц.Төмөрбат

ДЭЛХИЙН ДЭВЖЭЭНД МОНГОЛ ЦЭРЭГ

Нүүдэлчин омгийн Монгол цэрэг
НҮБ-ын тэнгэрт далбаагаа мандуулж
Галт зэвсэг, тэсрэх бөмбөгтэй
Галын шугаманд манаанд зогссон юм
Дахилт:
Энхийн сүүтэй энэхэн дэлхийд
Энхийг сахиулахаар бүгдээр эвсэж
Таван тивийн энхийн дайчидтай
Тангараг өргөж уухай нэгдсэн юм
Дээлтэй Монголын эрэлхэг цэргүүд
Дарийн утаатай халуун цэг рүү
Дэлхийн дэвжээнд энхийг сахиулахаар
Дээшээ босоолж умрыг зорьсон юм
Дахилт:

Соргог Монголын дайчин эрчүүд
Соёмбот тугнаасаа адис аваад
Харийн орныг өмгөөлөн тэмцэхээр
Халуун цэг рүү зориглон мордсон юм
Дахилт:

Энгэр дүүрэн итгэл тээсээр
Эзэн Чингисийн босоо цэргүүд
Эх орноо дэлхийд таниулахаар
Эвээ нэгтгэн дуулан мордсон юм
Дахилт:

Шүлэг: Р.Өнөржаргал
Хөгжим: Р.Ганбат

ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫН ДУУ

Алтан хүрээт сүлдэндээ
Адис хүртэн мэхийгээд
Амраг чамтайгаа зүрхэндээ тээгээд
Алсыг зорьсон дайчин бид
Дахилт:
Сахар, Судан, Косово
Саарал манант Афганистан
Аагим халуун Сьерра-Леон
Амгалан биш Ирак нутаг
Аль ч газар нэг л үүрэгтэй
Адилхан нэг л гарагтай
Аа аа аа
Адилхан бид нэг л зорилготой
Морьтон баатрын удамтай
Монгол төрийн цэргүүд бид
Эргэх дэлхийд энхийг дархлаад
Эх нутагтаа бид очно оо
Дахилт:

Шүлэг: Л.Төмөрбат
Хөгжим: Н.Чулуунхүү

ЭНХИЙН ТӨЛӨӨ МОНГОЛ ЦЭРЭГ

Эх орноосоо алс газарт
Энхийг сахиулах үйлсэд зүтгэсэн
Эвслийн хүчний эгнээнд нэгдэн
Эн зэрэгцэн хөл нийлүүлж
Дахилт:
Эзэн Чингисийн удмын
Эрэлхэг Монгол дайчид
Цэргийн тангарагтаа үнэнч байж
Цэнхэр дуулгатай жагсаж явна аа
Дэлхийн халуун цэгт очиж
Тэргүүн эгнээнд үүрэг гүйцэтгэж
Дээдийн заяатай Монгол эрсийг
Түүхэнд мөнхөлж алдрыг нь өргөсөн
Дахилт:
Амар амгалан орчлон ертөнцийг
Алаг үрсдээ үлдээх хүсэлтэй
Ашдын билэгтэй ард олныхоо
Ариун итгэлийг дааж яваа
Дахилт:

Шүлэг: СТА Р.Өнөржаргал
Хөгжим: СТА О.Эрдэнэцог

МӨРДЭСТЭЙ ЖОЛООЧ

Батлан хамгаалах ариун үйлсийн
Баатар зоригт дайчин эрсийн
Ялалт авчрах замыг гэтэлгэсэн
Явах зүгийн цувааг чиглүүлсэн
Тэргүүн дээрээ алтан соёмботой
Тэргэн дотроо цэргийн нөхөртэй
Төрийн ёслолд торгон цэрэгтэй
Түмний элч бид - цэргийн жолооч оо
Эрдэнийн хөлгийнхөө алтан жолоогоор
Энхийн үйлсийн эгнээнд багтсан
Дарийн утаатай харийн нутагт
Дайчин нөхдөө зоригжуулж явсан
Дахилт:
Ээлжгүй албанаас намайг хүлээсэн
Итгэлт сайхан ханьдаа яарсаар
Мөрөөдөл тээсэн замыг товчлоод
Мөрдөстэй жолооч дуулж явна аа
Далхилт:

Шүлэг: СТА Б.Отгонбаяр
Хөгжим: СТА А.Цоодол

ЭНХИЙН ЦЭРГҮҮД ДУУЛЖ ЯВНА

Энхийн манаанд хөл нийлүүлсэн
Эрэлхэг зоригт Монгол цэргүүдийн
Золбоо, нь хийморь нь өндөрт мандаж
Зорьсон үйлс нь сайн явна
Дуулга, туг нь энхийн билэгдэлтэй
Дайчин эрс дуулж явна
Энхийг сахиулах ариун үүрэгтэй
Эр цэргүүд алхаж явна
Даян дэлхийд нэр нь дуурссан
Дайчин цогтой Монгол цэргүүдийн
Дараалсан гавьяа нь дандаа тодорч
Дархан алдар нь мөнхөд бадарна
Дуулга, туг нь энхийн билэгдэлтэй
Дайчин эрс дуулж явна
Энхийг сахиулах ариун үүрэгтэй
Эр цэргүүд алхаж явна
Хилийн чанадад мөрөө гаргасан
Хийморь босоо Монгол цэргүүдийн
Эрэлхэг гавьяа нь мөнхөд тодорч
Эрхэм үйлс нь эгнээг бадарна
Дуулга, туг нь энхийн билэгдэлтэй
Дайчин эрс дуулж явна
Энхийг сахиулах ариун үүрэгтэй
Эр цэргүүд алхаж явна

Шүлэг Б.Дашзэвэг
Хөгжим П.Хаянхярваа

МОНГОЛ ЦЭРЭГ-ЭНХИЙН ЦЭРЭГ

Аавын хүү ээжийн охин байлаа ч
Алсын зам энхийн үйлстэн боллоо
Хүний нутаг бусдын амийг
Халдах дайснаас нь хамгаалж явна аа
Эх орон минь бахархаж байнааа
Эгэл түмэн минь хайрлаж байнааа
Чингис хааны удам угсаа, удам угсаа
Чин зоригтны үлгэр жишээ
Монгол цэрэг дэлхийн цэрэг
Монгол цэрэг дэлхийн цэрэг
Монгол цэрэг дэлхийн цэрэг

Шүлэг: С.Зоригтбаатар
Хөгжим: Р.Ганбат

ИРАКИЙН ДУУЛАЛ

Далдуу модны шархтай мөчирт
Сүү болон дусах гээд
Дайзтай сум бууны аманд
Цэцэг болон ургах гээд
Илчит сэтгэлээ хадаглан өргөөд
Иракийн тэнгэрт тугаа мандуулаад
Бид эвийн цэнхэр далбаа
Бид энхийн Монгол цэрэг ээ
Монгол цэрэг ээ
Эргэх дэлхийн сонор мялааж
Хуур болон дуурсах гээд
Эрхэт төрийн ариун сүлдийг
Хүлэг болгон онголох гээд
Илчит сэтгэлээ хадаглан өргөөд
Иракийн тэнгэрт тугаа мандуулаад
Бид эвийн цэнхэр далбаа
Бид энхийн Монгол цэрэг ээ
Монгол цэрэг ээ

Шүлэг: Р.Өнөржаргал
Хөгжим: О.Эрдэнэцог

ЭНХ ЦАГИЙН ТӨЛӨӨ

Дээд тэнгэрээс заяат төрсөн удмынхаа төлөө
Дэлүүн Болдогоос дэлхийг дагуулсан өвгөдийнхөө төлөө
Дээжээ өргөж өлзий ерөөсөн ээжийнхээ төлөө
Дээлээ хөөргөж адуугаа хураасан аавынхаа төлөө
Дахилт:
Түмэн үедээ тусгаар тогтносон улсынхаа төлөө
мөнхөд зүтгэе
Даян дэлхийн хүн төрөлхтний амгалангийн төлөө
Дайчин эрсийн амин тангараг энхийн төлөө
Уяхан замбуу тивдээ манддаг нарны төлөө
Уртын дуундаа улам саруулсдаг талынхаа төлөө
Шөнийн тэнгэрт сувдран цайрах оддынхоо төлөө
Шүүдэр сэгсэрч нарнаар сэргэх цэцэгсийнхээ төлөө
Дахилт:
Энгэрт яргуй нүдлэн ургах хаврын төлөө
Тэнгэрт шувууд зэллэн буцдаг намрынхаа төлөө
Энхэр сэтгэлд үргэлж нялхрах хайрынхаа төлөө
Эрхийн дээд мөнхийн шүтээн Монголынхоо төлөө
Дахилт:

Шүлэг: СТА Р.Өнөржаргал
Хөгжим: Б.Цацрал

БИ ЦЭРГИЙН БҮСГҮЙ

Үнэгчлэн нойрсох хүүгээ үүрийн туяанаар үнсээд
Өлгий сайхан орноо хамгаалж зогсоо ээжий
Үдшийн бүрий цагаар өргөө гэрээ зориод
Өлзийт сайхан ханьдаа цайгаа дээжлэх гэргий
Алтан мөрдөст заяандаа сүслэн залбирсан
Агуу дээдсийн хатан аргамжаа - би цэргийн бүсгүй
Саравчлан зогсоо буурлаа санан санан догдлоод
Саруул цэнхэр дэлхийгээ өмгөөлж зогсоо бүсгүй
Сартай нартай орчлондоо гэгээн үйлсийг бүтээгээд
Сайхан монгол орныхоо алдрыг дуурсгаж ээжий
Алтан мөрдөст заяандаа сүслэн залбирсан
Агуу дээдсийн хатан аргамжаа-би цэргийн бүсгүй
Харуулдан хүлээх нутагтаа цайны дээжээ өргөөд
Хамаг олны жаргалыг өрөөн залбирах ээжий
Хатан зоригт эрстэй энхийн жагсаалд жагсаад
Ханагар цэнхэр дэлхийгээ хамгаалж алхсан бүсгүй
Алтан мөрдөст заяандаа сүслэн залбирсан
Агуу дээдсийн хатан аргамжаа-би цэргийн бүсгүй

ЭНХ ТЭНГЭРИЙН ХАРУУЛД

Монгол Улсын төр, Засгийн газраас Ардын хувьсгалын ялалтыг бататган эх орноо батлан хамгаалах талаар хэрэгжүүлсэн олон чухал арга хэмжээнүүдийн нэг нь Ардын Цэргийн Нисэх хүчнийг байгуулж, хөгжүүлэн, бэхжүүлсэн явдал юм.

1924 онд хуралдсан МАН-ын III их хурлаар Цэргийн Яамны илтгэлийг хэлэлцээд гаргасан тогтоолд "Аливаа улс, цэрэг зэвсгийн хүчинд итгэх бөгөөд манай дайсан болох этгээд мөн шинэ маягийн зэвсэг бүхий тул хуягт тэрэг, нисдэг тэрэг зэргийг үлэмжээр олж бэлтгэхийг чухал болговол зохино" гэжээ.

Дээрх шийдвэрийг хэрэгжүүлэх хөдөлгөөн өрнөн, нийт ард түмэн батлан хамгаалах хэрэгт, түүний дотор нисэхийн техник, зэвсэг авахад зориулан агт морь, атан тэмээ, бэлэн мөнгө бэлэглэж эхэлсэн байна. Баримт дурдахад, одоогийн Булган аймгийн Сайхан-Овоо сумын харьяат малчин ард Наваан нисэх онгоц худалдан авахад зориулан 500 адуугаа бэлэглэж байжээ.

Ардын Хувьсгалын ялалтын дараахан Монголын төр, Засгийн газраас улс орныхоо батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлэх, эдийн засгаа хөгжүүлэх анхны алхмуудыг хийж байсан үед Зөвлөлт Холбоот Улсын сэтгэл, харамгүй тусламж шийдвэрлэх ач холбогдолтой байлаа. 1925 оны 5 дугаар сарын 25-ны өдөр ЗХУ-аас Монголын ард түмэнд бэлэглэсэн "Ю-13" нисэх онгоцны цувааг Улаанбаатар хотын Консулын дэнж дэх Нисэх онгоцны буудал дээр хүлээн авсан нь Монголын Нисэх хүчний түүхийн хуудсыг нээсэн юм.

Энэхүү нисэх онгоцны цувааг хүлээлгэн өгөх үеэр Зөвлөлтийн нисгэгчдийн ахлагч А.И.Лапин хэлэхдээ "Манай зөвлөлт засаг, түүний ард түмнээс Бүрэн эрхт тусгаар тогтносон Монгол Улсын Батлан хамгаалах хүчний хөгжилд зориулж нисэх онгоц нийлүүлэн тусалсныг бид хүлээлгэн өгөхөөр ирлээ. Та бүхэн байлдан олсон эрх чөлөө, засаг төрөө харийн түрэмгийлэгчдээс хамгаалахын төлөө Хувьсгалт цэргээ шинэ, боловсон техникээр зэвсэглэн, өөрийн засаг, төрийн ажиллагаанд туслах, сургууль эрдэмд боловсорч, эдийн засгаа хөгжүүлэхэд ашиглах хэрэгтэй" гэжээ. Энэ үеэр маршал Х.Чойбалсан хариу баяр хүргэж хэлсэн үгэндээ "...манай оронд буддын шашин дэлгэрч 350 шахам жил болоход тэнгэрт техник унасан хүн нисэх нь байтугай тал хээр нутагтаа тэмээ, морио унаад тайван аялах завшаан ч бидэнд олдоогүй. Ийм нисэх техникийг манай ард түмэн урьд нь үзээгүйгээр үл барам шувуунаас өөр юу нисдэгийг ч

материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжилтэй үндэсний боловсон хүчин бэлтгэх ажил эхэлжээ. Энэ үед МХЗЭ-ийн уриалгаар ирсэн залуучуудыг сонгон авч агаарын онгоцыг эзэмших ажиллагаанд сургаж эхэлсэн байна.

1928 онд ЗХУ-д цэргийн нисгэгч, техникч мэргэжлээр сонгон суралцуулахаар явуулсан. Үүнд анхны нисгэгчээр Б.Батцэрэн, Д.Жамбаа, Ч.Шагдарсүрэн, анхны онгоцны техникчээр Д.Дэмбэрэл, Л.Дамдин, Н.Нямдорж, Н.Хуудаан нар амжилттай төгсөж, эх орныхоо цэлмэг тэнгэрт шинэ зам нээн, алсын нислэгүүдийг амжилттай хийж эхэлсэн байна.

1928 оноос Нисэх отрядуудыг байлдааны зохион байгуулалтад шилжүүлж, ЗХУ-аас нэмж ирүүлсэн нисэх онгоцнуудыг жолоодох сургалтыг Монголын нисгэгчдэд Зөвлөлтийн мэргэжилтэн, багш нарын тусламжтайгаар богино хугацаанд явуулж, байлдааны нислэг бие даан хийх болсон.

1930 онд Төгс буянтын хүрээ, 1932 онд Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Завхан аймгуудад гарсан хувьсгалын эсэргүү нарын бослого, 1934 онд Байтаг богд, Цэнгэл, Цагаан гол, Дэлүүний чиглэлээр улсын хил хязгаарыг зөрчсөн Хятадын Гоминдааны дээрэмчдийг бут цохих байлдааны ажиллагаанд Монголын нисгэгчид анх удаа оролцон үүргээ амжилттай биелүүлж Монголын Ардын Цэргийн Нисэх хүчний өсөлт, бэхжилтийг харуулав.

Японы түрэмгийлэгчдийн өнгөлзөх нь улам нэмэгдэж ирсэн гучаад оны дундуур төр засгаас Нисэх хүчний отрядуудыг нэгтгэн Нисэх бригад болгон өргөтгөхийн хамт Шүхрийн тусгай албыг байгуулж, нисэх бүрэлдэхүүний байлдааны болон нислэгийн дадлагыг тогтмолжуулж, Зөвлөлтийн армийн туршлагатай мэргэжилтнүүдийг урьж ирүүлэх болжээ.

1936 оны эхээр Зөвлөлтийн мэргэжилтэн В.А.Судец (хожим нь ЗХУ-ын Нисэх хүчний маршал, ЗХУ, БНМАУ-ын баатар болсон) шүхрээр бууж түүний дараа Нисэх бригадын дарга Ц.Очир, М.Загдхорлоо (эмэгтэй) нар

үүргийг амжилттай биелүүлсэн байна.

1939 оны Халхын голын дайнд эгнээнээсээ 26 баатар, түүний дотор ЗХУ-ын анхны хошой баатрууд болох С.И.Грицевец, Г.П.Кравченко, Я.В.Смушкевич нарын Зөвлөлтийн баатарлаг нисэхийн анги, салбаруудтай Монголын Нисэх хүчний командлагч, хошууч генерал М.Зайсановын удирдсан

С.Тамир, С.Жанар, Т.Сугар, А.Цогнэмэх, Б.Дашаахүү нар БНМАУ-ын Гавьяат нисгэгч, Г.Шагдар, Б.Сурмаахорлоо, С.Очирдорж, Ч.Цэрэндорж нар БНМАУ-ын Нисэхийн Гавьяат техникч, И.Дамба БНМАУ-ын гавьяат холбоочин цолоор шагнуулжээ.

БНМАУ, ЗХУ-ын баатар, сансрын нисгэгч, Ж.Гүррагчаа Монголын Ардын Армийн Цэргийн Нисэх хүчний дайчдын

Д.Лхам, М.Бөмбөг нарыг нэрлэж болно.

Монгол Улсын Цэргийн Нисэх хүчний нисгэгч, инженер техникийн ажилтныг 1928-1995 оны хооронд ЗХУ-д бэлтгэж ирсэн. Харин 1995 оноос эхлэн ОХУ, БНХАУ, АНУ, БНЭУ, БНСУ, ХБНГУ, БНТУ-уудад цэргийн нисэхийн мэргэжлийн бүрэн сургалтад хамрагдаж байна.

1966 оноос эхлэн цаг



Цэргийн Нисэх хүчний нисгэгчид хамтран оролцож Японы Милитаристуудад сүйрлийн цохилт өгөхөд үнэтэй хувь нэмэр оруулсан.

Эдгээр байлдааны үед Монголын Ардын Армийн олон арван дарга, цэрэг зориг гарган гарамгай гавьяа байгуулж төрийн дээд шагнал хүртсэний дотор 1936 онд нисгэгч, хурандаа Д.Дэмбэрэл БНМАУ-ын Агаарын зоригт баатар, дивиз командлан захирагч, нисгэгч Ч.Шагдарсүрэн Улсын Эрхэм Нисгэгч (1965 онд баатар цол нэхэн шагнагдсан), хошууч генерал, нисгэгч Д.Гунгаа 2009 онд Монгол Улсын баатар цолоор, Д.Жамбаа, Н.Мөнхөө, Ж.Лхамсүрэн, А.Дагва, Б.Санж, Б.Өлзийбат зэрэг хүмүүс Байлдааны гавьяаны Улаан тугийн одонгоор шагнагдсан байна.

1945 оны Чөлөөлөх дайнд Монголын Ардын Цэргийн Нисэх хүчний нэгтгэл, ангиуд байлдааны бэлэн байдалд шилжихийн зэрэгцээгээр тагнуулын нислэг хийх, холбоо, цэргийн удирдлагын тусгай үүргийн нислэг үйлдэх зэргээр үүрэг даалгаврыг нэр төртэй биелүүлсэн юм.

1925-1957 онд Монголын Ардын Цэргийн Нисэх хүчин, байлдааны Р-1 (ДН-9а), Р-5, И-15, И-16, И-15 БИС, Ил-2, Як-9 онгоцуудаар нисэж сургууль, байлдааны даалгаврыг биелүүлж байжээ.

1957 оноос Цэргийн Нисэх хүчин, түүний анги, салбарууд бүрэн бүрэлдэхүүнээрээ Иргэний агаарын тээврийн үүргийг биелүүлэхийн хамт дайчилгааны даалгавартай байж, тодорхой хэмжээний цэргийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, цэргийн цол, дүрэмт хувцас, Ардын Цэргийн 018 дугаар анги гэсэн харилцах хаягтайгаар 1986 он хүртэл ажиллажээ. Энэ цаг мөчөөс Иргэний нисэх энгийн болжээ. Дээрх нэр хүндтэй үүргийг биелүүлэхэд хөдөлмөрийн өндөр амжилт гарган гавьяа байгуулсан олон хүнд төрийн дээд шагнал хүртээсний дотор Д.Гунгаа, У.Даравгар, Г.Раднаа, С.Лхагважав, Д.Цэрэндорж, Д.Чодин, Л.Пүрэвсүрэн,

жагсаалаас 1981 оны 3 дугаар сарын 22-ны өдөр "Союз-39" хөлгөөр сансарт ниссэн.

Цэргийн Нисэх хүчний хамт олноос БНМАУ-ын Улсын Бага Хурлын гишүүнээр Ч.Шагдарсүрэн, М.Зайсанов, БНМАУ-ын Ардын Их Хурлын гишүүнээр Г.Раднаа, У.Даравгар, Т.Бадарч, Д.Гундаа (2 удаа), Р.Жамьян, С.Цэрэндорж, Д.Чодин, С.Ванчиндорж, Ж.Гүррагчаа (4 удаа) нар сонгогдон төрийн эрхийг барилцжээ.

БНМАУ-ын Ардын Их Хурлын орлогч даргаар, мөн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдаар Ж.Гүррагчаа, БНМАУ-ын Тээврийн Яамны сайдаар С.Ядамсүрэн, Батлан хамгаалахын дэд сайдаар Б.Эрдэнэбат, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ө.Сүх-Очир, Өмнөговь аймгийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар Б.Нямбуу нарын нисэхийнхэн томилогдон ажиллаж байв. Цэргийн нисэхийн дарга нараас генерал цолыг М.Зайсанов, Д.Гунгаа, С.Санжмятав, Ц.Геннадий, Ж.Гүррагчаа, Т.Дашдэлэг, Б.Батбаяр нар хүртжээ. Цэргийн нисэхийнхнээс шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэргийг Ц.Геннадий, Ч.Даш, А.Даваасүрэн, боловсрол ухааны доктор (Ph.D)-ын зэргийг Л.Санж, Л.Лхагваа, Г.Даш, Б.Эрдэнэбат, Ж.Гүррагчаа, Ч.Болдбаатар, Г.Амармэнд нар цөмөөрөө ЗХУ-ын нисэхийн сургуулийн төгсөгчид юм. Түүнчлэн, Цэргийн нисэхийн мэргэжлийн нисгэгч, инженер-техникчдээс зохиолч, орчуулагчид олноор төрсөн юм. Тухайлбал, М.Горькийн нэрэмжит Олон улсын шагналт, зохиолч, орчуулагч С.Бадраа, БНМАУ-ын Соёлын гавьяат зүтгэлтэн, зохиолч Д.Цэрэндагва, Монгол Улсын Төрийн хошой шагналт, эрдэмтэн зохиолч Ч.Лодойдамбын нэрэмжит шагналт, зохиолч Д.Сурьяа, Монголын Зохиолчдын Эвлэлийн шагналт зохиолч Т.Батжаргал, С.Амартайван орчуулагч Л.Бадарч, Д.Дамбийжанцан, Ц.Даагаа,

үеийн нөхцөл, байдлаас шалтгаалан БХЯ-нд Нисэхийн алба, хэлтэс, Нисэх хүчний командлагч-Армийн авиацийг удирдах газартай, түүний харьяанд Нислэгийн хөдөлгөөнийг удирдах Улсын нэгдсэн төв, анги, салбаруудыг шинээр байгуулж 1966-1995 онд эх орны тэнгэрийн харуулд үүрэг гүйцэтгэж байсан нь өдгөөгийн Зэвсэгт хүчний Агаарын цэргийн суурь болсон.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 230 дугаар тогтоолын дагуу ИБНАУ-д НАТО-гийн тэргүүлсэн "Аюулгүй байдлыг хангах Олон улсын хүчин"-ний бүрэлдэхүүнд багтсан Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэргийн инженер-техникийн ажилтнууд "Ми-17" нисдэг тэргэнд засвар, үйлчилгээг хэрхэн хийх талаарх сургалтыг явуулсан. Нисдэг тэрэгний техникийн засвар, үйлчилгээний сургалтын бүлэг нь Афганистан Улсын нийслэл Кабул хотын "КАЯА" баазад байрлан Афганистаны Үндэсний Армийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд тус улсын Агаарын хүчний чадварыг дээшлүүлэх зорилгоор "Ми-17" нисдэг тэрэгний бүрэлдэхүүнд сургалт, дадлагыг зохион байгуулж, засвар үйлчилгээ хийх үүргээ онц сайн гүйцэтгэсэн. 2010-2014 оны хугацаанд 16 дамжааны хичээлийг явуулж Афганистаны Нисэх хүчний 200 гаруй офицер, ахлагчийг амжилттай сургаж, бэлтгэн агаарын хөлөгт ажиллах эрхийн гэрчилгээ олгожээ.

"Агаарын зайг нисэхэд ашиглах тухай" (2003 он), "Улсын нисэхийн тухай" (2003 он) хуулиудыг чанд мөрдөн, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.

Зэвсэгт хүчний Агаарын Цэрэг, түүний Нисэх хүчний бүрэлдэхүүн төр засгаа улам нягтаар тойрон хүрээлж, эх орныхоо агаарын торгон хилийг соргогоор хамгаалах ариун үүргээ цаашид нэр төртэй биелүүлэх зориг эрмэлзэл дүүрэн байна.

Бэлтгэл хурандаа Я.ДАВААСАМБУУ



мэдэхгүй байлаа. Эрх чөлөөгөө олсон Монголын ард түмэн бид Зөвлөлт Оросын ард түмний ачийг үүрд үл мартана" гэсэн байна.

1925 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн Ардын Засгийн газрын 21 дүгээр хурлаар Монголын Ардын Цэргийн Нисэх хүчин байгуулах тухай шийдвэр гаргаснаар Нисэх хүчний анхны салбарыг байгуулж, цаашид түүний

600-800 метрийн өндрөөс шүхэрлэн буусан нь мэргэжил нэгтэй нөхдөө үлгэрлэхийн хамт нисэх хүчнийг сурталчлахад чухал ач холбогдолтой болжээ.

1935-1936 онд Халхын сүм, Булан дэрс, Адаг дулаан, 1939 онд Халхын голын орчмоор халдан довтолсон Японы түрэмгийлэгчидтэй явуулсан дайнд манай нисэх хүчний анги, салбарууд идэвхтэй оролцож, командлалаас даалгасан

Дугаарын зочин

Энэ удаагийн дугаарын зочин бол Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн ротын ахлагч, сургагч ахлагч Б.Гантөмөр. Зэвсэгт хүчинд 20 дахь жилдээ ажиллахдаа бууриа сэлгээгүй элитийн батальоны жинхэнэ бүтээгдэхүүн бөгөөд НҮБ-ын энхийг дэмжих болон Олон улсын цэргийн зургаан ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн арвин туршлагатай энхийг сахиулагч юм. Түүний ажиллагаанаас олж авсан туршлага, үүрэг гүйцэтгэж байсан үеийнх нь талаар ярилцлаа.

Цэргийн хүн болсон талаар ярилцлагаа эхэлье. Энэ сонголтыг өөрөө хийсэн үү?

-Аав, ах хоёр маань хоёулаа цэргийн хүмүүс байсан. Аав маань барилгын цэрэгт алба хаасан бэлтгэл хошууч. Харин ах маань 1997 онд Зэвсэгт хүчний 150 дугаар ангийг анх үүсэн байгуулагдсан цагаас нь эхлэн алба хаасан ахлагчдын нэг бөгөөд 2000 онд авто ослоор харамсалтайгаар нас барсан юм. Тэр цагаас л цэргийн хүн болж аав, ах хоёрынхоо залгамж халаа болох хүсэлтэй болсон. Яг энэ үед Зэвсэгт хүчний 150 дугаар ангид ажиллуулах мэргэжлийн ахлагч бэлтгэх сургалт эхлэх гэж байгаа талаар сонсоод БХИС-ийн Ахлагчийн сургуульд элсэн орж суралцсан. Монгол Улсын Зэвсэгт хүчний мэргэжлийн тусгай батальон, дээр нь ахын минь алба хааж байсан анги учир өнөөдрийг хүртэл энэ ангидаа хоёргүй сэтгэлээр ажиллаж байна.

Анх 150 дугаар ангийн үүдээр орж байсан дэд ахлагч, өнөөдрийн сургагч ахлагч хүртэл ямар ямар албан тушаалуудыг дамжиж байв?

-Цэргийн хүн бүрийн л давах даваа, туулах зам ижил гэж боддог. Энэ л замаар өөрт оногдсон үүргийн дагуу явна. 2001 онд анх буудагчаар томилогдож, дараа нь ротын

ахлагч нартаа тавьж ажилладаг. Шижигнэсэн залуустай хамт ажилладаг учраас даргын хувьд үүрэг өгөх үе, ах шиг нь найз шиг нь байж зөвлөх үе ч бий. Тиймээс энэ бүгдэд нь тохируулан залуустайгаа тулж ажиллахын зэрэгцээ алба болон хувийн тал дээр нэг алхам ахиулахуйц зөвлөгөө, заавар

ХАРИЙН ТЭНГЭРТ ТӨРИЙН ДАЛБААГАА МАНДУУЛАД ТӨРИЙН ДУУЛЛАА ЭГШИГЛҮҮЛНЭ ГЭДЭГ ХАМГИЙН ТОРГОН АГШИН

өгч ажиллахыг хичээдэг. Одоо үед хувь хүн өөрийгөө дайчилж чадвал хөгжих боломж нээлттэй байна. Тухайлбал, манай ангид бүх төрлийн ном, сурах бичиг, танхим, төхөөрөмжүүд байна. Ялангуяа гадаад хэл сурч, бие бялдраа хөгжүүлэх илүү боломжтой. Тиймээс өдөрт ганц цагийг л өөртөө зориулж чадвал оюун ухааны болон бие бялдрын хөгжлийг хүн бүр өөртөө цогцлоож чадна.

НҮБ болон Олон Улсын цөөнгүй ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн туршлагынхаа талаар ярихгүй юу?

MISS" ажиллагаанд мөн ротын ахлагч, 2018 онд Афганистан улсад явагдаж байгаа ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтарсан Цэргийн хамгаалалтын ротын долоодугаар ээлжид буудагч, оператороор тус тус үүрэг гүйцэтгэсэн.

Ажиллагаа бүр өөрсдийн гэсэн онцлогтой байж цэргийн алба хаагчид багагүй туршлага хуримтлуулсан байдаг. Таны хувьд ...

-Бүх ажиллагаа өөрийн гэсэн онцлогтой. Иракийн эрх чөлөө ажиллагаанд нэлээдгүй туршлага хуримтлагдсан.

захирагчийн үүргийг гүйцэтгэх хугацаандаа хүн удирдах арга барилд суралцсан. Чад, ТАБНУ-д явагдсан НҮБ-ын "MINURCAT" энхийг сахиулах ажиллагаанд бие даан шийдвэр гаргах эрх бүхий салааны захирагчийн орлогчоор үүрэг гүйцэтгэсэн. Тиймээс хэрхэн зөв шийдвэр гаргах, эргүүл хийж байгаа цэргүүдийнхээ аюулгүй байдлыг ханган ажиллах талаар төлөвлөгөө, тактик боловсруулах дөр суусан. Энэ мэт олон дадлага, туршлага, сургагч бүрийг ажиллагаанаас ажиллагаа бүрд хамт үүрэг гүйцэтгэсэн захирагч, удирдлага, хамт олноосоо суралцаж албандаа хэрэгжүүлж байна даа. Энд нэг зүйлийг сонирхуулахад зургаан ажиллагааны дөрөвт нь ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын ажиллагааны удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга, газрын орлогч дарга, хурандаа Б.Баатар даргатай хамт үүрэг гүйцэтгэж байсан.

Залуус ажиллагаанд явснаар дээр дурдсан дадлага, туршлагаас гадна нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд томоохон дэмжлэг болдог. Таны хувьд ...

-Тодорхой хэмжээгээр нийгмийн асуудлаа шийдэж чадсан. Ангийнхаа албан тушаалын байранд анх өрх тусгаарлаж тусдаа гарсан. Тэгээд ажиллагаанд явж ирэх бүрдээ залуу хүмүүст тулгардаг санхүүгийн асуудлуудаа тодорхой хэмжээгээр шийдсэн гэж боддог.

Цэргийн хүн болсноороо бахархаж байсан үе нь хэзээ вэ?

-Миний хувьд ажиллагааны газар оронд төрийн далбаагаа мандуулж, төрийн дууллаа эгшиглүүлэх үед огшиж, цэргийн хүн болсноороо бахархдаг. Мөн үүргээ амжилттай гүйцэтгээд эх орондоо газардах тэр мөч үнэхээр сайхан. Энэ мэдрэмжийг магадгүй цэргийн бид л мэддэгдэг байх. Сүүлийн ажиллагаандаа үүргээ гүйцэтгээд ирэхдээ эхнэртэйгээ ярилцаж байгаад хүүхдүүдээ гэнэтийн бэлэг барих гээд хэлэлгүй гэртээ шууд ирсэн

юм. Тэр үед хүүхдүүдийнхээ баярлахыг хараад ядарсан мэдрэмж хормын дотор л үгүй болох шиг болсон.

Таны цаашдын зорилго ...

-Сурч боловсрох маш олон шат намайг хүлээж байгаа.

Цэргийн бид гэртээ зарцуулах цаг хомс. Ялангуяа тань шиг албатай хүний хувьд ...

-Сайн аав болж байгаа гэж хариулъя. Учир нь том охиныхоо эцэг, эхийн хуралд нь анх удаа очиж үед анги удирдсан багш нь "Чанцалдуламын аав нь ийм хүн байдаг байсан юм уу? Танай охин дандаа л аав ажилтай, хөдөө явсан, гадагшаа явсан гэдэг" гэж билээ. Тэгэхэд нь одоо л хүүхдүүдээ цаг зарцуулах хэрэгтэй юм байна гэж бодсон. Мөн бага хүүгээ төрөөд долоо хоногтой байхад нь Афганистан руу явж байсан. Долоон сарын дараа ирэхэд мөлхдөг болчихсон байж билээ. Энэ мэт зүйлс намайг гэр бүлдээ хэр цаг зарцуулдаг байсныг харуулж байгаа байх. Байхаасаа байхгүй нь их. Ар гэрийг маань авч явдаг хүн бол миний хань А.Бүдсүрэн юм. Бид гурван хүүхэдтэй. Миний хань болсноосоо мэргэжлээрээ нэг ч удаа ажиллаж чадаагүй боловч хэзээ ч гомдол хэлж байгаагүй.

Тэгвэл ханьдаа дайх үг байгаа даа ...

-Чамдаа баярлалаа гэж хэлье. Өмнө нь хэлмээр үе зөндөө байдаг ч хэлж байгаагүй юм байна. Б.Гантөмөрийнх гэдэг айлгыг нэр бүтэн, мөр бүтэн авч явж байгаа нь ханийн маань гавьяа юм.

Сүүлийн асуултыг танд үлдээе ...

-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн удирдлага, хамт олон, хамт үүрэг гүйцэтгэсэн нийт энхийг сахиулагчдаа "Олон улсын энхийг сахиулагчдын өдөр"-ийн баярын мэндийг өргөн дэвшүүлж. "Энхийг сахиулна гэдэг цэрэг хүний хийх ажил биш ч гагцхүү цэрэг хүн л үүнийг хийж чадна" гэдэг үгийг та бүгддээ хэлье.

Ярилцсанд баярлалаа.

Хошууч Д.ОЮУНГЭРЭЛ



Гэр бүлийн хамт

пулемётчин, тасгийн захирагч, салааны захирагчийн орлогч, тэгээд одоогийн албан тушаалд томилогдон ажиллаж байна.

Ротын ахлагчийн маань албандаа хандах хандлага, зарчмын талаар сонирхвол ...


-Цэргийн хүн туйлбаргүй байж болохгүй. Албандаа зүтгэлтэй, сэтгэлтэй байж хамт олон, ангийн ажил явна. Миний хувьд цагтаа ирж, цагтаа тарахаас эхлээд ажлын цаг ашиглалтыг үр дүнтэй байлгаж чөлөөт цагаараа өөрийгөө боловсруул гэдэг шаардлагыг

-Анх 2003 онд "Иракийн эрх чөлөө" ажиллагааны нэгдүгээр ээлжид буудагч, 2007 онд Сьерра-Леон улсад явагдсан НҮБ-ын "UNMIL" энхийг сахиулах ажиллагааны гуравдугаар ээлжид тасгийн захирагч, 2009 онд Чад, ТАБНУ-д явагдсан НҮБ-ын "MINURCAT" энхийг сахиулах ажиллагаанд салааны захирагчийн орлогч, 2013 онд Афганистан улсад явагдсан "Тогтвортой эрх чөлөө" ажиллагаанд ротын ахлагч, 2015 онд Бүгд Найрамдах Өмнөд Судан улсад явагдаж байгаа "UN-

Тухайлбал, ажиллагааны өмнөх бэлтгэл, сургалтын үед заагдаж байсан эргүүл, хамгаалалтын сургалтыг бодитоор хэрэгжүүлсэн. Мөн тэнд бүтээн байгуулалтын ажил их хийгдэж байсан учир төрөл бүрийн ажилд дадсан. Миний хувьд цэргийн хүн болсноос хоёр жилийн дараа оролцсон ажиллагаа байсан учир тэр үед цэргийн хүнд байх тэсвэр, хатуужил, сэтгэл зүйн бэлтгэл зэргийг олж авсан гэж боддог.

Сьерра-Леон дахь ажиллагаанд тасгийн

Үндэсний бахархал, Өв соёл




Зөвлөлтийн мэдээлэх товчооноос

8 дугаар сарын 30-ны байлдааны мэдээ
Алс дорнодод онц өөрчлөлтгүй байна. 8 дугаар сарын 29-нд манай цэрэг Японы цэрэг, офицер 9000, генерал 2-ыг олзлов.

Зөвлөлтийн мэдээлэх товчоо.
Батлан хамгаалахын төв архивын сан хөмрөгөөс "Улаан од" сонин. 1945.09.02 Дугаар 188 /2262/ Хуудас 3

"МОНГОЛ ЦЭРЭГ-ЭНХИЙН ЦЭРЭГ"

Монгол цэргийн музей нь "Монгол Улс Энхийг дэмжих ажиллагаанд" үзүүллийн хэсгийг 2018 онд Монгол Улс, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойг тохиолдуулан АНУ-ын элчин сайдын яамны дэмжлэгээр шинэчлэн дэглэсэн. Энэхүү хэсэгт шинэ цагийн зэвсэгт хүчний түүхийн алтан хуудсыг бүтээлцэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчнээс энхийг дэмжих ажиллагаанд оролцсон цэрэг, дайчдын түүхэнд холбогдох эд өлгийн зүйл болон гэрэл зураг баримтыг дэлгэн үзүүлж жилээс жилд өргөжүүлэн үзэгч олны мэлмийг мялааж байна.



дурдвал дэлбэрсэн минаны үлдэгдэл, монгол цэргийн алтан амийг хамгаалж бууны суманд оногдсон дуулга, цэргийн багуудын туг, дэлхийд үнэлэгдсэн энхийг сахиулагч нарын шагнал урамшуулал, дурсгалын зүйл зэрэг 100 гаруй биет үзэмэр дэглэгдэн үзэгч олны хүртээл болж байна.

Олон нийттэй харилцах ажилтан-Тайлбарлагч Д.СОДБИЛЭГТ

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч
Хурандаа
Батжаргалын
ОТГОНБАЯР

Эхийг "Соёмбо" сонин
редакцад бэлтгэж,
"Соёмбо принтинг" хэвлэх
үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламгыг хямд нийтэлнэ.
*Зар, рекламны үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сониний нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Mil_newssoyombo@yahoo.com
Утас: 70001029